# Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Сувилахуйн сургууль

Хөтөлбөрийн нэр: Хөдөлмөр засал

Индекс: D091502

Шинжээчийн баг:

Ахлагч: Б.Одончимэг

Гишүүд: Д.Цэнджав

Д.Тулгамаа

2022.04.20-21

**Агуулга**


**Товчилсон үгийн тайлбар** .......... 4

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт** .......... 5

**II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга** .......... 6

**III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт** .......... 7

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .......... 7

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа .......... 11

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .......... 14

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .......... 24

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа .......... 31

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа .......... 37

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт .......... 47

**IV. Уулзалтад оролцогчдын нэрс** .......... 52

I. Багш нарын нэрс .......... 52

II. Оюутнуудын нэрс .......... 53

III. Ажил олгогчдын нэрс .......... 54

IV. Төгсөгчдийн нэрс .......... 54

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал** .......... 55

**YI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

**YII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АШУҮИС | Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль |
| БШУСЯ | Боловсрол Шинжлэх Ухаан Спортын Яам |
| БШУЯ | Боловсрол Шинжлэх Ухааны Яам |
| ГССҮТ | Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв |
| ДЭМБ | Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЕХ | Ерөнхий хороо |
| МАУОУС | Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль |
| МИДСК | Монголын Их дээд Сургуулиудын Консорциум |
| МУБИС | Монгол Улсын Боловсролын Их Сургууль |
| МУИС | Монгол Улсын их Сургууль |
| МХЗОК | Монголын Хөдөлмөр засалч оюутны клуб |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| НЭМС | Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль |
| НЭМСТ | Нийгмийн Эрүүл Мэндийн Сувилахуйн Тэнхим |
| ОУ | Олон улс |
| ОЭШХ | Оюутны Эрдэм Шинжилгээний Хурал |
| СА | Сургалтын алба |
| СБЗГ | Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар |
| СЗСҮХТ | Сэргээн Засах Сургалт Үлйдвэрлэл Хөгжлийн Төв |
| СС | Сувилахуйн сургууль |
| ССТ | Суурь Сувилахуйн Тэнхим |
| СУИС | Соёл Урлагийн Их Сургууль |
| СЭЗГ | Санхүү эдийн засгийн газар |
| СЭМҮТ | Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТӨСБЗА | Төгсөлтийн Өмнөх Сургалтын Бодлого Зохицуулалтын Алба |
| ТӨСБЗГ | Төгсөлтийн Өмнөх Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар |
| УНТЭ | Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг |
| УХТЭ | Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг |
| ХЗДХ | Хөдөлмөр Засалчдын Дэлхийн холбоо |
| ХНХЯ | Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам |
| ХӨСҮТ | Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв |
| ХСҮТ | Хавдар Судлалын Үндэсний Төв |
| ХХ | Хөтөлбөрийн хороо |
| ЦХШУИС | Цүрихийн Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургууль |
| ШУГТЭ | Шастины Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг |
| ЭБЭХСТ | Эх Барих Эх Хүүхдийн Сувилахуйн Тэнхим |
| ЭМХТ | Эрүүл мэндийн хөгжлийн төв |
| ЭМШУТНС | Эрүүл мэндийн шинжлэх ухааны төв номын сан |
| ЭМЯ | Эрүүл Мэндийн Яам |
| ЭХЭМҮТ | Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв |

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

| | | |
|---|---|---|
| **Сургуулийн нэр /Монгол, Англи/** | АШУҮИС, Сувилахуйн сургууль MNUMS, School of Nursing | |
| **Сургалтын хөтөлбөрийн нэр** | Хөдөлмөр засал | |
| **Индекс** | D091502 | |
| **Шинжээчид** | Ахлагч:<br>Б.Одончимэг- Шихихутуг их сургуулийн Чанарын албаны дарга<br>Гишүүд:<br>Д.Цэнджав- Улсын 2-р төв эмнэлэгийн Сургалт, гадаад харилцааны албаны дарга, доктор<br>Д.Тулгамаа- Италийн АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч | |
| **БМИҮЗ-ийн Мэргэжилтэн** | Б.Мядагмаа Магадлан итгэмжлэл хариуцсан ахлах шинжээч | |
| **Төлөвлөгөө** | **Он сар өдөр** | **Хийгдсэн байх ажлууд**<br>/Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/ |
| | 2022.04.11 | Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. № А/76 |
| | 2022.04.11 | Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан |
| | 2022.04.18 | Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн. |
| | 2022.04.20-21 | Сургууль дээр 2 өдөр хуваарийн ажилласан. |
| | | Сургуулийн бэлтгэсэн илрэл нотолгоотой танилцсан. |
| | | Сургуулийн анги, танхим, номын сан, лабораторитай танилцсан |
| | | Сургуулийн багш, оюутан нартай уулзалт хийсэн. /танхимаар/ |
| | | Төгсөгчид, ажил олгогч нартай уулзалт хийсэн. /онлайнаар/ |
| | 2022.05.09 | Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн. |
| **Шалгуур шаардлага /журам/** | БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолын гуравдугаар хавсралт. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага | |

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөдөлмөр засал мэргэжил нь анх Америк, Европод 100 гарй жилийн өмнө сууриа тавьж түүхийн олон нугачааг даван өдгөө дэлхийн 100 гаруй оронд хөгжсөн. Улс орны онцлогоос шалтгаалж хөдөлмөр засалчийг бэлтгэх, мэргэжлийн болон эрдмийн зэргийн хөтөлбөрүүд болон тус мэргэжлийн хөгжил олон улсын хэмжээнд харилцан адилгүй байна. АНУ-д 235, Япон улсад 191, Германд 187, Их Британи улсад 55, Австрали улсад 55, Өмнөд Солонгос улсад 60 их сургууль хөдөлмөр засалчийг бэлтгэж байна.

АНУ-д хийсэн судалгаагаар хөдөлмөр засал нь 2019 оны хамгийн сайхан 50 ажлын 4-т орж жилдээ 74000 долларын цалин авдаг, 2018-2028 он хүртэл хамгийн хурдтайгаар буюу 18%-иар өсөх мэргэжил гэж тогтоожээ.

Монгол улсад анх удаа бакалавр зэрэгтэй хөдөлмөр засалч мэргэжилтнийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг 2014 оноос АШУҮИС-ийн Сувилахуйн сургуульд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар Монгол Улсад энэ мэргэжилтнийг бэлтгэж буй цорын ганц хөтөлбөр юм. Эдүгээ найм дахь жилдээ сургалтын үйл ажиллагаа явуулж дөрвөн удаагийн төгсөлтөөр 30 хөдөлмөр засалч төрж гаран эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын салбаруудад тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Хөдөлмөр заслын олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан Монгол улсын Дээд боловсролын хуулийн хүрээнд боловсруулсан тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойш улам боловсронгуй болгон АШУҮИС-ийн ЗЗ-ийн 2016 оны 11 сарын 7-ны өдрийн хурлын шийдвэр, ЭЗ-ийн дэргэдэх НТЗ-ийн 2016 оны 11 сарын 2-ны өдрийн хурлын тэмдэглэл, СС-ийн Эрдэмтдийн зөвлөлийн 2016 оны 9 сарын 19-ний өдөр, 10 сарын 7-ны өдрийн хурлуудаар тус тус хэлэлцүүлэн 2016 онд нэг удаа шинэчлэн сайжруулсан байна.

Хөтөлбөрийг боловсруулж төлөвлөж эхлэх үеэс одоог хүртэл Япон, Швейцар зэрэг улсын их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллан хөтөлбөр боловсруулах, багшлах боловсон хүчинг бэлтгэх, оюутан солилцооны гэх мэт олон хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлж байна. Оюутан солилцооны хөтөлбөрөөр төгсөлтийн өмнөх сургалтад анхааран 2-4 дүгээр дамжаанд суралцаж буй оюутнуудыг хамруулдаг байсан бол 2020 оноос төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтад анхааран төгсөгчдийг хамруулах болсон. Хөдөлмөр засалч мэргэжлээр төгссөн нэг төгсөгч магистрын сургалтанд сурахаар 2021 оноос Япон улсын засгийн газрын тэтгэлгээр Гунма их сургуульд суралцаж байна.

Өнөөгийн байдлаар хөдөлмөр засалч мэргэжилтнийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ерөнхий суурь хичээлүүдийг 16 багш, мэргэжлийн суурь хичээлүүдийг 7 багш, мэргэшүүлэх хичээлүүдийг 12 багш зааж байна. АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийг хөдөлмөр засалч мэргэжилтнээр төгсөгчийн эзэмшвэл зохих 17 чадвар буюу хөтөлбөрийн үр дүнг тодорхойлж хөтөлбөрийн нэгдмэл байдал, хамаарлын матриц үүсгэн заагддаг хичээлүүдээс эзэмших мэдлэг, чадвар, хандлагын холбоо нийцлийг хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх багш нартай хамтран тодорхойлжээ.

## III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

**1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

**Илрэл нотолгоо:**

Өөрийн үнэлгээний тайлан, сургалтын хөтөлбөр, нотлох баримтуудтай танилцахад нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байна.

Тухайлбал, Монгол улсын хүн амын дундах халдварт бус өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаанд (10.000 хүн ам тутамд) амьсгалын тогтолцооны өвчин (1339.4), хоол боловсруулах тогтолцооны эмгэг (1056.8) зүрх судасны тогтолцооны өвчин (848.1), гэмтэл хордлого гадны шалтгаант эмгэг (578.4)-ийн тохиолдлууд, 100 мянган хүн ам тутамд 200-290 тархины харвалтын тохиолдол бүртгэгддэг нь дэлхийн улсуудтай харьцуулахад өндөр байна. Эдгээр өвчний улмаас өвчтөний ачаалал даах чадвар, хөдөлгөөн, үйл ажиллагааны чадвар хязгаарлагдан, хөдөлмөр эрхлэх чадвар алдагдаж, амьдралын чанарыг бууруулж байгааг хэрэгцээ шаардлагын үзүүлэлт болгожээ.

“Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг “Эрүүл амьдралыг хангах, бүх насны хүмүүсийн сайн сайхан байдлыг дэмжин урагшлуулах” хэмээн тодорхойлсон. Мөн Швейцарийн Женев хотноо 2017 онд зохион байгуулагдсан “Сэргээн засах 2030-Үйл ажиллагааны уриалга” чуулга уулзалтаас сэргээн засах тусламжийг 21-р зууны эрүүл мэндийн гол түлхүүр болно хэмээн үзсэнийг олон улсын чиг хандлагын хүрээнд авч үзжээ.

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 228 тоот тушаалаар “Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги”-ийг баталж хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлан сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх зорилго тавьжээ. Стратегийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сэргээн засах тусламж, үйлчилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох; сэргээн засах тусламж, үйлчилгээний хүний нөөцийг хөгжүүлэх; сэргээн засах тусламж, үйлчилгээнд шинэ техник, технологийг нэвтрүүлэх; сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах; сэргээн засах тусламж, үйлчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх гэсэн 5 зорилт дэвшүүлжээ. Стратегийн хүрээнд “Тархины харвалтын 5 сэргээн засахын удирдамж”, “Зүрхний шигдээсийн сэргээн засахын удирдамж” удирдамжид “Сэргээн засах эмчилгээний багт сэргээн засалч их эмч, сувилагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч болон нийгмийн ажилтан заавал багтана” гэж заасан нь хөдөлмөр засалч мэргэжилтний ач холбогдлыг тодорхойлон харуулж байна.

Монгол улсын хэмжээнд ажиллаж буй 27083 эмнэлгийн орыг чиглэл бүрээр нарийвчлан тооцоолбол нийт 2500 орчим хөдөлмөр засалч эрүүл мэндийн салбарт

шаардлагатайн дээр нийгмийн хамгаалал, боловсролын салбарт шаардлагатай тоо тодорхойгүй байгаа нь эрэлт хэрэгцээний түвшинг илэрхийлнэ.

Багш, удирдлагатай хийсэн ярилцлага, нотлох баримтаар тухайн хөтөлбөрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Гунма Их сургуулийн Хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөртэй харьцуулан боловсруулсан байна. Хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөрийн агуулгад Швейцар улсын Цүрихийн Хэрэглээний шинжлэх ухааны их сургуулийн мэргэжилтэн багш нараас авсан зөвлөгөөг тусган оруулж, Дэлхийн хөдөлмөр заслын холбооны стандарт шаардлага, Европын холбооны TUNING лавлагаануудыг харгалзсан нь нотлогдож байна.

Хөтөлбөр боловсруулахдаа хөдөлмөр, нийгэм, анагаах ухааны мэдлэгийн нарийн нийлмэл цогц бүхэллэг зарчмаар хөдөлмөр заслын үйлчилгээг үзүүлэх чиг хандлагыг баримталсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Үндэсний болон олон улсын чиг хандлагыг баримжаалан, улс орон, иргэдийн эрүүл мэндийн тулгамдсан хэрэгцээнд үндэслэн боловсруулагдсан байна.
- Бакалаврын хөтөлбөрийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Гунма Их сургуулийн Хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөр, Швейцар улсын Цүрихийн Хэрэглээний шинжлэх ухааны их сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан боловсруулсан байна.
- АШУҮИС-ийн Нэр томьёоны зөвлөлөөр хэлэлцүүлж, хөтөлбөрийн нэр томьёог цэгцэлсэн байна.
- Тухайн хөтөлбөр нь анх удаа боловсруулагдсан, харьцангуй шинэ хөтөлбөр учир олон талаас нь хөгжүүлэх боломжтой.

**1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

Өөрийн үнэлгээний тайлан, сургалтын хөтөлбөр, нотлох баримтуудтай танилцахад хөтөлбөрөөр төгсөгчийг мэргэжлийн хувьд 7 чиглэлийн үүрэг, 17 хүрэх үр дүнтэйгээр загварчилсан байна.

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг тодорхойлохдоо олон улсын болон үндэсний бодлогын дараах эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан үзэл баримтлал, шийдвэрүүдийг тусгасан байна.

- ДЭМБ-ын “Сэргээн засал” – 2030 уриалга
- ЭМЯ-ны Сэргээн засах тусламж үйлчилгээний стратеги, төлөвлөгөө (2021-2025)
- МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030
- Алсын хараа 2050 (МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого)
- 2024 он хүртэл Төрөөс Боловсролын болон Эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
- БМИҮЗ-ийн Хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуур
- БСШУ-ны Сайдын 2014 оны А/174 дугаар тушаал, Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага

АШУҮИС, СС-ийн зорилго, зорилтуудтай нийцүүлэн тодорхойлсон хөтөлбөрийн зорилго, зорилтын баримт бичгийг "ХӨДӨЛМӨР ЗАСАЛ" сургалтын хөтөлбөр нэрээр БШУСайдын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаал "Мэргэжлийн чиглэл, индекс батлах тухай" тушаал, БШУ-ны Сайдын Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага А/174 тоот тушаалд нийцүүлэн боловсруулжээ. http://www.mnums.edu.mn сайтад хөтөлбөрийн танилцуулгыг байршуулсан байна.

Бакалаврын боловсролтой хөдөлмөр засалч мэргэжилтэн бэлтгэхийн тулд хөдөлмөр заслын шинжлэх ухааны философи үндсийн мэдлэгт тулгуурлан үйлчлүүлэгчийн бие махбод, мэдрэл сэтгэцийн үйл ажиллагаа, бодит ба нийгмийн орчны үр нөлөө, танин мэдэхүй, оюун ухааны чадварууд, хөдөлмөрийн гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн хийхийг хүссэн, хийх шаардлагатай байгаа хөдөлмөрийн хэлбэрүүдийг судалж, үнэлгээ өгөх, түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг илрүүлж, өдөр тутмын аливаа үйл ажиллагаанд оролцох боломжийг хүмүүст олгох, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн сэргээн засах эмчилгээний эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, аливаад шүүмжлэлтэй хандах, өөртөө дүгнэлт хийх чадварыг хөгжүүлэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн (PLO)-г тодорхойлохдоо Стаблибиэм (2007) боловсруулсан сургалтын хөтөлбөрийн үнэлгээний CIPP загварыг ашиглан асуумж судалгаа авч, үр дүнг тусгасан нь судалгааны ажлын тайлангаар батлагдаж байна.

Хөтөлбөрийн үр дүнг томьёолохдоо Блуумын таксономийн түвшинд харгалзуулан тодорхойлсон нь багш нарын уулзалт, хөтөлбөрийн боловсруулах ажлын алхам бүрийн баримтуудаас харагдаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг судалгаанд суурилан үндэслэл сайтай боловсруулсан байна.
- Блуум таксономийн танин мэдэхүйн түвшинд харгалзуулан тодорхойлсон нь суралцахуйн үр дүнг үнэлэх боломжтой болгосон байна.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнг боловсролын үр дүн буюу PEO, суралцахуйн үр дүн буюу PLO, судлагдахууны үр дүн буюу CLO түвшинд харилцан уялдаатай гүнзгий төлөвлөх шаардлагатай.
- Хөтөлбөрөө үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхдээ БСШУЯ, ADB-ийн хамтран хэрэгжүүлсэн "Үр дүнд суурилсан боловсрол" төслийн сургагч багш нартай хамтран ажиллах шаардлагатай.

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгийг бүтцийн хувьд БСШУ-ны Сайдын 2014 оны А/174 дугаар тушаал, Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын загварыг

баримтлахын зэрэгцээ үр дүнд суурилсан сургалтын технологийн суралцахуйн үр дүнг тодорхойлох аргачлалын дагуу боловсруулсан нь “ХӨДӨЛМӨР ЗАСАЛ” сургалтын хөтөлбөрийн баримт бичгээр нотлогдож байна.

Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг процесс нь Хөтөлбөрийн дэд хорооны хурлын тэмдэглэл, сургалтын хөтөлбөрийн хөгжил хариуцсан багийн хурлын тэмдэглэл, Сувилахуйн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл зэргээр нотлогдож байна.

Мөн хөтөлбөрийн шинэчлэл, хичээлийн агуулгын давхардал, хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ, зохион байгуулалтыг Сувилахуйн сургуулийн захирлаар ахлуулсан нийт 17 гишүүнтэй АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Хөтөлбөрийн дэд хороо, Сувилахуйн сургуулийн багш нараас бүрдсэн 8-н ажлын хэсгийн нэг болох 10 гишүүнтэй Сургалтын хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын хэсэг тус тус хариуцан ажилладаг нь бүтэц зохион байгуулалтын тушаал, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, шийдвэрүүдийн баримт бичгээр нотлогдож байна.

Сургалтын нэгдсэн төлөвлөгөө нь 122 багц цагийг 4 жилийн хугацаанд судлахаар төлөвлөгдсөн бөгөөд ерөнхий суурь судлагдахууны багц -20,5%, мэргэжлийн суурь судлагдахууны багц-23%, мэргэжлийн судлагдахууны багц-48,4% байгаа нь бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж байна.

Хичээлийн буюу судлагдахууны хөтөлбөрийн баримт бичгийг ISO9001:2015 стандартаар “Y30- хичээлийн хөтөлбөр боловсруулах үйл явц”, ”Y60 хичээл хөтлөн явуулах”, “Y10-сургалтын төлөвлөгөө боловсруулах үйл явц”-ын зураглалын дагуу боловсруулж, батлан мөрдөж байгаа нь баримтжуулсан мэдээллэр нотлогдож байна.

Хөдөлмөр засал хөтөлбөрөөр төгсөгчдөд зориулсан “Төгсөлтийн шалгалтын сорилын эмхэтгэл” 2019, “Төлөвлөгдсөн зорилготой гардан шалгалт” 2019 зэрэг материалуудаар суралцахуйн үр дүнгийн үнэлгээний агуулга, арга зүйг тодорхойлсон нь батлагдаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- ISO9001:2015 стандартын Y30, Y60, Y10 үйл явцын зураглалын дагуу хичээлийн /судлагдахуун/ хөтөлбөрөө боловсруулдаг.
- Суралцахуйн эцсийн үр дүнг үнэлэх үнэлгээний нэгдсэн сорил, шалгалтын сантай, түүнийгээ суралцагчдад нээлттэй байлгадаг.
- Сургалт, хичээлийн хөтөлбөрийг хянан сайжруулахдаа сургалтад оролцогч талуудыг оролцуулж, хамтын шийдвэр гаргадаг.
- Оролцогч талуудын оролцоог тухай бүр нотлох баримт бүрдүүлж, хадгалдаг зэрэг сайн туршлага байна.

**Анхаарах асуудал:**

1. Оюутны ачааллыг суралцах хугацааны туршид тэнцвэржүүлэхэд анхаарах
2. Нэг багц цагтай хичээлүүдийн төлөвлөлтийг багасгахад анхаарах
3. Заавал судлах ёстой “Гамшгийн менежмент” судлагдахууныг төлөвлөлтөд тусгахад анхаарах

**Зөвлөмж:**

- Номын санд бодит болон цахим байдлаар сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийг хүртээмжтэй байршуулж, сургалтад оролцогч талуудад нээлттэй байлгах шаардлагатай.
- Сургалтын хөтөлбөрт суралцахуйн үр дүнг тодорхойлсон ч хичээлийн хөтөлбөр, ээлжит хичээлийн түвшинд PLO /program learning outcom/-г хангахын тулд CLO /course laerninig outcome/ болон TLO /topic learning outcome/ зорилтуудыг тодорхойлж, хэрэгжүүлэх шаардлагатай.

**1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөдөлмөр засал хөтөлбөрийн хүрэх үр дүн болох 17 (PLO) ур чадварыг эзэмшүүлдэг хүрээнд хичээлийн хөтөлбөрийн хамаарлын матриц үүсгэснээр хичээлийн агуулга, суралцагчдад олгох ур чадваруудыг тодорхой болгосон байна. Эдгээр 17 (PLO) ур чадварыг төгсөгчид хэрхэн эзэмшсэн байдлыг ажил олгогч нар хэрхэн тодорхойлох талаар судалгаа хийсэн байна.
- Хөдөлмөр засалчийн ерөнхий ур чадварыг 7 үндсэн дүрээр тодорхойлсон байна.
- Хөдөлмөр засалчийн мэргэжлийн ур чадварыг 6 үндсэн бүлгээр мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлж хичээл тус бүрийн хүрэх үр дүнг блүүмийн таксонамоор тодорхойлж эрдэмтдийн зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 22/04/22/10 дугаартай хурлын протоколоор баталгаажсан байна. Хурлын шийдвэрт зохих засваруудыг хийгээд зарим орчуулгын үг хэллэгийг АШУҮИС-ийн нэр томьёоны хурлаар хэлэлцүүлэх болсон байна.
- Хичээлийн хөтөлбөрийн 5 боть номд орсон нийт хичээлийн 26% нь онол, 74% нь дадлага байгаа нь зохистой харьцаатай, давхардалгүй, хичээлүүд харилцан уялдаатай байна.
- Хөтөлбөрийн хичээлүүдийн агуулгын залгамж холбоог хөтөлбөрт хэвтээ босоо тэнхлэгээр индексжүүлж уялдаа холбоог тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн үнэлгээг CIPP загвараар судалгааны түвшинд хийж үе шаттай хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгааг харлаа. (Эрдмийн чуулган – 63, ЭМШУ сэтгүүлийн тусгай дугаар Vol 17 №5 {61} 2021)

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага**

- Хөтөлбөрийн үнэлгээ, үр дүн, мэргэжилтний цогц чадамжийг нотолгоонд суурилсан судалгааны аргаар хийж байна.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг 2 удаа хийсэн байна. /Эрүүл мэндийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой, бас хөдөлмөр засалч гэсэн мэргэжлийн индекс батлагдсантай/

- Хөдөлмөр засалчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар хандлагуудыг тодорхойлохдоо Дэлхийн холбоо, ОУ-ын жишиг болон хөтөлбөрийн оролцогч талууд багш, оюутан, төгсөгч, ажил олгогчдын саналыг тусгасан байна.
- Боловсруулсан цогц чадамжид хөтөлбөрийн нийт багш нараас санал авч, тухайн хичээлээр эзэмшүүлдэг чадамж тус бүрийг Блүүмийн таксономоор тодорхойлсон.

**Анхаарах асуудал:**

- Хөдөлмөр заслын хөтөлбөрийн эмнэл зүйн хичээл, дадлагын цагийг нэмэх
- Үр дүнд суурилсан суралцахуйн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ нотолгоонд суурилсан арга ашиглах

**Зөвлөмж:**

- Хөдөлмөр засалч мэргэжилтний цогц чадамжид тусгагдсан мэргэжлийн үг хэллэгийн талаар сэргээн засах салбарын мэргэшсэн эмч, судлаачдаас зөвлөгөө санал авч, дүгнэсний дараа нэр томъёоны хурлаар оруулах.
- Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх туршлага бүхий бусад их дээд сургуулиуд, энэ чиглэлийн судалгаагаар мэргэшсэн баг, эрдэмтдээс зөвлөгөө авах
- Төгссөн хөдөлмөр засалчийн ажлын байран дахь мэдлэг, ур чадварыг үнэлж, дээрх хөтөлбөрөөр эзэмшсэн мэргэжил нь одоогийн эрүүл мэндийн салбарын шаардлага хэрэгцээг хангаж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийсний үндсэн дээр дахин хөтөлбөрийн шинэчлэлийг хийх

### 2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй сургалтын арга зүйг “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу боловсруулсан байна. Хичээлийн болон суралцагчийн онцлог тус бүрээс шалтгаалан багш нар сургалтын арга, техникүүд (контент өрөө, виртуал сургалтын орчин, бүрэн тоноглогдсон ур чадварын өрөө)-ийг сонгон суралцагч төвтэй сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Хичээлийн хөтөлбөр болон дадлага ажлын дэвтэр, оюутан багш нартай хийсэн ярилцлагаас гардан үйлдэл, тохиолдолд, асуудалд суурилсан, багаар хамтран ажиллах, дүрд тоглох, тонгоруу сургалтын арга, эргэцүүлэн дүгнэх, харилцаанд суурилсан, бүлгийн хэлэлцүүлэг зэрэг нэгдмэл агуулга бүхий сургалтын аргуудыг ашигласан байна.
- Сургалтын арга зүйг алхамчилсан байдлаар ISO 9001-2015 стандартын үйл явцын зураглал Ү10, Ү30, Ү60-ыг ашиглан загварчилсан байна.
- СС-ийн Цахим сургалтын ажлын хэсгийн тайлан болон шинээр байгуулсан “Контент“ өрөөний зохион байгуулалт, үйл ажиллагаа, ИСУМС дэх багш нарын цахим сургалтын үйл ажиллагаатай танилцахад 2020 оноос цахим сургалтын үйл ажиллагаа өндөр түвшинд хүрсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нар сургалтын арга зүйгээ хичээлийн онцлогт тохируулан оюутан төвтэй, хайрцагт баригдуулалгүй, өргөн хүрээнд чөлөөтэй сэтгэх, асуудлыг олж харж, түүнийг шийдвэрлэх чадварыг эзэмшүүлсэн нь төгсөгчидтэй хийсэн ярилцлагаас харагдаж байсан.

- Оюутнууд зарим туслах хэрэгслийг гараараа хийж сурч байгаа нь ажил дээр гарсан хойноо ч хэрэгжүүлэх боломжтой байна.
- Төсөлд суурилсан суралцахуйн (PBL) аргыг амжилттай хэрэгжүүлэн “Амьдралын үргэлжлэл” төслийн төлөвлөлт, Контент, тайлангаас харагдаж байна. Төсөлд суурилсан сургалтын арга нь суралцагчдад мэргэжлийн болон зөөлөн ур чадваруудыг хамгийн сайн эзэмшүүлсэн нь төслийн багийн гишүүдийн ярилцлагаас харагдаж байв.
- Багш нь лекцээ 100 хувь интерактив хэлбэрт оруулсан

**Анхаарах асуудал:**

- Суралцагч төвтэй сургалтын арга барилыг хэрэгжүүлэхэд сургалтад хэрэглэгдэх багаж, хэрэгслийг оюутан өөрөө хийхэд өртөг, зардал гарах тул оюутанд учрах санхүүжилтийн дарамт үүсч болзошгүйг анхаарах
- Сургалтын арга зүйд ашиглаж байгаа гарын авлага, үнэлгээний асуумж нь гадаад орны соёлын хүрээнд хөдөлмөр, ахуйг оруулсан байна.

**Зөвлөмж:**

- Оюутан өөрөө хичээлд хэрэглэх багаж, хэрэгслийг хийх бол зардлыг сургуулиас гаргадаг байх
- Сургалтын арга зүйд монгол ахуй соёлыг тусгасан арга барил (шагай наадгай, дээс томох, гурил зуурч, илдэх, ааруул тавих, бууз чимхэх...гм)-уудыг оруулах. Энэ нь монгол ахуй, хөдөлмөрөөр дамжуулж чадвар алдалтыг сэргээхэд чухал ач холбогдолтой юм.
- Хөдөлмөр засалчид нь чадвар алдсан хүмүүстэй удаан цагаар ажилладаг тул зан авирын өөрчлөлтөд түр орсон, хэцүү үйлчлүүлэгчтэй, тэдний ар гэрийнхэнтэй хэрхэн харьцах талаар сургалтын хөтөлбөртөө бие даан заавал судлах хичээл хэлбэрээр оруулах. Сэтгэл судлал, сэтгэл заслын хичээл оруулдаг байх.

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хичээлийн хөтөлбөрт тус бүрт оюутны үнэлгээнүүдийг аман, эссэ бичлэг, цахим сорил, эмнэл зүйн тохиолдлын сорилоор мэдлэгийн хүрээг үнэлдэг байна.
- Ур чадварыг гардан үйлдэл, өртөөлчилсөн шалгалт, эмнэл зүйн тохиолдол танилцуулах, өвчтний үнэлгээ, эмчилгээний менежментийн шалгалтаар үнэлдэг байна.
- Портфейль үнэлгээ, 360 хэм үнэлгээ зэргээр үнэлж байна.
- Хичээл бүрийн төгсгөлд суралцагчдаас авдаг санал асуулгад суралцагчийг дүгнэх арга болон үнэлсэн үнэлгээнд сэтгэл ханамжийн судалгааг авч мөн ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч, суралцагч төгсөгчдийн ур чадварыг үнэлүүлж хэвшсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Бүрэн тоноглогдсон ур чадварын өрөөнд оюутан шалгалт өгөх явцад шалгагч багш нь өөр өрөөнөөс хянах, микрофоноор чиглүүлж байгаа нь оюутан сандрахгүй байх,

оюутны эрхийг хүндэлсэн байна. Мөн шалгуулж байгаа оюутанг бусад оюутанууд өөр өрөөнөөс дэлгэцээр харах боломжтой нь шалгалтын үйл явц ил тод, үнэлгээ шудрага байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Үнэлгээг Портфейль үнэлгээ, 360 хэм үнэлгээ зэргээр үнэлж байна.

**Анхаарах асуудал:**

- Үнэлгээг хийж байгаа арга барил нь гадаад орны соёлыг тусгасан байна.

**Зөвлөмж:**

- Үнэлгээг хийж байгаа арга барил гадаад орны соёлыг тусгасан байгаа тул монгол зан заншил, ахуй, соёлыг тусгасан үнэлгээг оруулах, оюутан монгол ахуй руу чиглүүлж сэтгэж байгаа байдалд үнэлгээ өгөх

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

Анги танхим: Сургуулийн барилга 1985 онд баригдсан. Сургалтын зориулалттай барилга байгууламж нь “Олон нийт иргэний барилга БНбД31-03-03” -д заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативыг хангасан өөрийн эзэмшлийн сургалтын байртай.

2021 онд хийсэн С.Булганчимэг нарын “Хөдөлмөр засал хөтөлбөрийн чанар хүртээмжийн үнэлгээ” судалгаанд хамрагдсан нийт 53 оролцогчдын 60% нь сургалтын орчин тохилог гэж хариулжээ.

Оюутанд чиглэсэн ээлтэй орчин: 2021 онд оюутнууд хувийн шүүгээтэй болсон. Хичээлийн байрыг камержуулсан. Харуул хамгаалалтын газартай болсноор сургуулийн байранд гардаг хулгайн гэмт хэрэг буурсан.

Амбулатори, клиникийн эмнэлэг, мэргэжлийн 30 байгууллагад түшиглэн сургалт явуулж байна. Үүнд: ЭХЭМҮТ, УНТЭ, УХТЭ, ШУГТЭ, Сэргээн засахын үндэсний төв, ХСҮТ, Сэргээн засах клиник эмнэлэг, СЭМҮТ, ГССҮТ, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төв, Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв, Мөнгөн гүүр эмнэлэг, Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолбор, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, Энэрэлийн түүчээ ТББ-ын Хүслийн ордон цэцэрлэг г.м.

Биеийн тамирын заал, Кофе шоптой. 2014 оноос сургуулийн байранд ажиллаж буй бүх кафе, хүнсний дэлгүүр, хоолны газруудад бэлэн гоймон, бохь, хуванцар аяга гэх мэт.

Лаборатори:

Сувилахуйн сургуулийн мэргэжлийн 7 тэнхмийн сургалтын лаборатори, ур чадварын 2 төв, ИСНЭмнэлгийн харьяа Үүдэн эмнэлэг болон сургалтйн бааз эмнэлгүүд болох Сэргээн засах клиник эмнэлэг, ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, УХТЭ, Сувиллын цэцэрлэг яслийн 10-р цогцолбор, Хүүхдийн төв сувиллын сэргээн засах тасаг гэх зэрэг эрүүл ахуйн шаардлага, аюулгүй байдлыг хангасан өрөө тасалгаа, анги танхимд түшиглэн хөтөлбөрийг хэрэгжүүлж

байна. Анги танхим, тоног төхөөрөмж нь боловсролын байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг бүрэн хангасан.

2013 онд Bayanzurkh Rotary Club, Японы Maebashi Rotary Club-тай хамтын ажиллагааны төслийн хүрээнд хөдөлгөөн, хөдөлмөр заслын лабораторийг тохижуулсан.

2020-2021 оны хичээлийн жилд Хөдөлмөр заслын оюутны суралцах орчныг сайжруулах үүднээс “Хүүхдийн хөдөлмөр заслын өрөө” “Сургалтын зориулалттай ариун цэврийн өрөө”-г тус тус шинээр тохижуулсан.

**Сувилахуйн сургууль дээрх хөдөлмөр заслын сургалт явуулж буй лаборатори**

| № | Лабораторийн нэр | Харьяалал | Чиглэл |
|---|---|---|---|
| 1 | Ур чадварын лаборатори – 2 өрөө | Бие бялдрын судлалын тэнхим | Хөдөлмөр заслын чиглэлийн эмнэл зүйн дадлага |
| 2 | Хүүхдийн хөдөлмөр заслын өрөө | Бие бялдрын судлалын тэнхим | Мэргэжлийн хичээлийн дадлага, семинар |
| 3 | Сургалтын зориулалттай ариун цэврийн өрөө (хүртээмжтэй болгож зассан) | Бие бялдрын судлалын тэнхим | Мэргэжлийн хичээлийн дадлага, семинар |
| 4 | Оюутны эрүүл мэндийг дэмжих төв | Бие бялдрын судлалын тэнхим | Хөдөлмөр заслын чиглэлийн эмнэл зүйн дадлага<br>Төгсөлтийн судалгааны ажил |
| 5 | Эмнэлзүйн ур чадварын төв | Сувилахуйн сургууль | Клиник анагаах ухаан<br>Гэмтэл<br>Мэдрэл судлал |
| 6 | Анатоми лаборатори | Анатомийн тэнхим | Анатомийн гаргалгаа хий |
| 7 | Физиологи лаборатори | Анатомийн тэнхим | Эд эсийн судалгаа |
| 8 | Биохимийн лаборатори | Биохими, лабораторийн тэнхим | Биохимийн судалгаа |
| 9 | Их сургуулийн нэгдсэн эмнэлэгт суурилсан клиник лаборатори | Биохими, лабораторийн тэнхим | Клиникийн лаборатори |
| 10 | Микробиологийн лаборатори | Бичил амь, Дархлал судлалын тэнхим | Микробиологи |
| 11 | Эмнэлзүйн эмгэг судлалын лаборатори | Бичил амь, Дархлал судлалын тэнхим | Клиник лаборатори |
| 12 | Эмийн лаборатори | Эм судлалын тэнхим | Эмийн туршилт судалгаа |
| 13 | Хэлний интерактив сургалтын лаборатори | Гадаад хэлний төв | Англи хэл, анагаахын англи хэл |
| 14 | Контент өрөө | Цахим сургалтын өрөө | Цахим хичээл бэлтгэх өрөө |
| 15 | Аудио өрөө | Цахим сургалтын өрөө | Цахим хичээл бэлтгэх өрөө |

**Бааз эмнэлэг дээрх хөдөлмөр заслын сургалт явуулж буй лаборатори**

| № | Лабораторийн нэр | Харьяалал | Чиглэл |
|---|---|---|---|
| 1 | УНТЭ, Сэргээн засах тасаг | Хөдөлмөр заслын лаборатори | Мэргэжлийн хичээлийн дадлага |
| 2 | УХТЭ, Сэргээн засах тасаг | Хөдөлмөр заслын лаборатори | Мэргэжлийн хичээлийн дадлага |
| 3 | УГТЭ, Сэргээн засах төв | Хөдөлмөр заслын лаборатори | Мэргэжлийн хичээлийн дадлага |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | ГССҮТ, Сэргээн засах тасаг | Хөдөлмөр заслын лаборатори | Мэргэжлийн хичээлийн дадлага |
| 5 | Сувиллын цэцэрлэг, яслийн 10-р цогцолбор | Хөдөлмөр заслын лаборатори | Мэргэжлийн хичээлийн дадлага |

Хөдөлмөр заслын анги нийт 28 танхимд бакалаврын зэргийн боловсрол олгож байна. Үүнээс:

- Лекцийн танхим - 6
- Дадлагын танхим/ ерөнхий, суурь хичээлийн танхим орвол/-22
- Бааз эмнэлэг-21
- Хөдөлмөр заслын мэргэшүүлэх дадлагын өрөө-2

Цахим орчин, бие даан болон багаар ажиллах орчны хангалт:

БШУ-ны сайдын 2014 оны 7-р сарын 4-ний А/299 болон 2014 оны А/359 дугаар тушаалыг үндэслэн “Cloud University” системийг АШУҮИС-ийн захирлын 2015 оны 5-р сарын 6-ны өдрийн А/55 дугаар тушаалаар нэвтрүүлэн ашиглаж байна.

Уг системд администратор, сургалтын албаны мэргэжилтэн, багш, суралцагч, эдийн засагч, удирлагууд тус тусын эрхээр интернет орчинд ашиглаж болдог тул хаанаас ч хэзээ ч хандаж болдог.

Оюутны веб: нийт 14350 оюутан ашиглаж байна.

Багшийн веб: нийт 948 багш ашиглаж байна.

2015 онд АШУҮИС-т Цахим сургалтын төв болон Олон улсын сайбер их сургууль байгуулагдаж, цахим сургалттаы холбоотой үйл ажиллагааг зохицуулахаар “АШУҮИС-д цахим сургалт эрхлэх журам”-ыг боловсруулан, 2016 оны 11-р сарын 9-ний өдрийн АШУҮИС-ийн захирлын А/118 тоот тушаалаар батлуулан сургалтын үйл ажиллагаанд мөрдөж байна. Цахим сургалтын үйл ажиллагааг “Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам”, “Суурь сургалтын хөтөлбөрийг зохицуулах журам”, “Суралцагчийг үнэлэх журам”, “Сонгон суралцах хичээлийг зохион байгуулах журам” зэрэг эрхзүйн хүрээнд зохион байгуулж байна.

Онлайн сургалтын систем:

2003 оноос Зайн сургалт, зайн оношилгооны төв, 2007 оноос теле-хурал, мүүдл системийг хөгжүүлэх сургалтанд ашиглаж зайн сургалтыг зохион байгуулж байсан. 2015 онд Цахим сургалтын төв болон Олон улсын сайбер их сургуулийг байгуулан, магистрын түвшний сургалтыг Сувилахуйн болон бусад 8 чиглэлээр цахим хэлбэрээр зохион байгуулж байна.

Е-хурлын өрөө (CISCO):

Цахим сургалтын төв нь интернет протокол хаягийг ашиглан хөдөө, орон нутгийн 3 салбар сургууль, 21 аймгийн эрүүл мэндийн байгууллагууд, гадаадын хамтын ажиллагаатай их сургуулиудтай шууд холбогдох онлайн хурлын төхөөрөмжтэй. Тус төхөөрөмжийг ашиглаж олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, уулзалт, сургалтуудыг зохион байгуулж байна.

Гар утсанд зориулсан аппликейшн (eMNUMS):

eNMNUMS аппликейшн нь IOS болон андройд үйлдлийн системтэй төхөөрөмжид ажиллах боломжтой. Хэрэглэгчид өөрсдийн ухаалаг төхөөрөмжид суулган, онлайнаар хялбар, хаанаас ч суралцах боломжийг бүрдүүлсэн, багш, суралцагч нь сургах болон суралцах олон төрлийн арга хэлбэрийг агуулснаараа давуу талтай.

Цахим сургалтын контент студи:

Сувилахуйн сургууль нь цахим сургалтын чанарыг сайжруулах үүднээс 2021-2022 оны хичээлийн жилд цахим контент өрөөг шинээр тохижуулан багш нарын интерактив хичээл, подкаст, видео хичээлд ашиглах сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмж байршуулан ашиглаж эхэлсэн.

Цахим сургалтын аудио өрөө:

2020-2021 оны хичээлийн жил цахим сургалтын чанарыг сайжруулах зорилгоор багш нарын видео хичээл, цахим хичээлийн аудио өрөөг шинээр тохижуулан ашиглаж байна.

E-erdem сургалтын платформ:
Сувилахуйн сургууль нь 2020-2021 оны хичээлийн жилд цар тахлын үеийн цахим сургалтын чанарыг сайжруулах зорилгоор www.e-erdem.mn сургалтын платформыг шинээр байгуулан төгсөлтийн өмнөх ба дараах сургалтын материал, цахим сургалтууд, төгсөлтийн өмнөх сорилуудыг байршуулан ашиглаж байна.
Шинжээчид сургууль дээр ажиллах хугацаанд нийт 27 анги, танхимаар очиж, үзсэн бөгөөд оюутны сургалтын орчин бүрдсэн байна гэж үзэж байна.

**Ярилцлага:**

Шинжээчид I-IV ангийн нийт 15 оюутантай уулзсан бөгөөд сургалтын орчинг хангалттай гэж хариулсан.

Төгсөгчидтэй ярилцах үед зарим төгсөгчид тэдний оюутан байхад сургалтын орчин тааруу байсан, харин дараа сургууль дээрээ очиход орчин маш их сайжирсан тухайгаа дурдаж байсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын орчин хүний эрхэд суурилсан хандлагатай байсан: өвчтөн бүрийг үнэлгээг хийж, хувь хүн бүр дээр хөтөлбөр гарган ажиллаж байна.
- Сургалтын орчин бүрдсэн: анги танхим хангалттай, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэглэхүүн гэх мэт.
- Багшийн ажиллах орчин: Багш нарын ажиллах орчинг бүрэн хангасан, судалгаа, шинжилгээ хийхэд зориулсан анги танхимыг тусгайлан тоноглосон байсан.
- Сургуулийн гадаад орчин цэвэрхэн, үүдэндээ стандартын дагуу барьсан налуу замтай.
- Хөдөлмөр заслын дадлагын анги танхим, бие засах өрөө нь 1-р давхарт байрласан нь маш давуу талтай байсан. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хүмүүс ирж үйлчлүүлэхэд бүрэн боломжтой орчноор хангагдсан байна.
- Оюутнуудын бие даан суралцах орчинг сургуулийн давхар бүрт хангасан, оюутны эрүүл мэндийг дэмжих төв, хоолны газар, кофе шоп, буфет, тогны разетка, гэрэлтүүлгийг шийдсэн ширээ сандал, интернет холболтын утас, разетка бүхий цахим сургалт дэмжих булан, оюутнуудад мэдээлэл хүргэдэг ухаалаг самбар, цахим номын сан, смарт төхөөрөмж цэнэглэх тогны разетка бүхий сандлуудыг байрлуулсан.
- Бие даан болон багаар ажиллах орчин: Анги танхим, лабораториудыг хичээлийн бус цагаар ашиглах, 25 суурин компьютер бүхий сургалт судалгааны төв, 40 суурин компьютер бүхий компьютерийн лаборатори, цахим номын сан, хичээлийн байрны эмнэлзүйн SIMMAN програм хангамж бүхий ур чадварын 2 төв, номын сангийн цахим уншлагын төв зэргийг ашиглаж байна.

**Анхаарах асуудал:**

- Сургуулийн гадна төв хаалган дээр стандартын дагуу баригдсан налуу замтай, 1 хүртээмжтүй ариун цэврийн өрөө байгаа боловч, сургуулийн барилга хуучных учир дэд бүтцийн хүртээмжийн асуудал тааруу. Хөгжлийн бэрхшээлтэй хүн зөвхөн 1-р давхарт орох боломжтой байна. Зарим ангийн хаалга нарийн, довжоотой байна. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан сурах тохиолдолд барилгын хүртээмжийн асуудал тулгарах магадлалтай байна. Гэхдээ сургуулийн барилгыг шинээр барьж байгаа бөгөөд Японы стандартаар баригдаж байгаа учир энэ асуудал удахгүй шийдэгдэнэ гэж найдаж байна.
- Оюутнуудыг дадлагажуулах ажил дээр хэд хэдэн анги нээвэл зүгээр байна. Тухайлбал: Өдөр тутмын үйл ажиллагааг дэмжих (ADL) өрөө, хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдрах орчинг танилцуулах өрөө (гал тогоо гэх мэт), Туслах технологийн цех, Туслах технологийн үзүүлэнгийн өрөө зэргийг тохижуулбал оюутнууд дадлагажихад үнэтэй

хувь нэмэр оруулна. Эдгээр өрөөг тохижуулахад АХБ-ны “.......”төсөлтэй холбовол зүгээр.

- Мөн АШУҮИС дээр Туслах технологийн техникч бэлдэх анги нээх ажлыг судлах хэрэгтэй. Туслах технологи нь хөдөлмөр засалч, хөдөлгөөн засалттай нягт хамтран ажиллах шаардлагатай байдаг. Туслах технологийн техникч Монгол улсад байхгүй мэргэжил бөгөөд энэхүү сэргээн засалтын мэргэжилтэн бэлтгэхэд хувь нэмрээ оруулах боломжтой.

**Зөвлөмж:**

- Аливаа засвар хийж, дэд бүтцийн хувьд хүртээмжтэй болгоход БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм, БД 31-101-04 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль, БНбД 31-..-21 “Бүх хүн түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж барилга байгууламжийн орон зай, орчны хүртээмжийг дээшлүүлэх (хангах) төлөвлөлт”-ийг барьж ажиллавал зүгээр.

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа**

Сургалтын бодлого зохицуулалтын газар, багш, суралцагчид, суралцагчдын эцэш эх хоорондын харилцаанд мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглаж болох UNIMIS систем нь ажлын бүтээмжийг дээшлүүлэх, сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох давуу талтай. Мөн нэгдсэн тайлан судалгааг их сургуулийн ерөнхий дүр төрхийг бүхий л түвшинд ойлгомжтой байдлаар тодорхойлж, их сургуулийг зөв, оновчтой удирдан чиглүүлэхэд туслах гол хэрэгсэл юм.
Мэдээллийн систем, програм хангамж нь сургалтын мэдээллийн нэгдсэн санг бий болгох үндсэн зорилгын хүрээнд ашиглаж байгаа бөгөөд их сургуулийн хөгжлийн үзүүлэлтийг тодорхойлж, цаашдын бодлого, чиглэл, шийдлийг зөв, оновчтой удирдан чиглүүлэхэд нэгдсэн тайлан судалгааг ашиглах гол үндсэн хэрэгсэл юм.

**Удирдлага, багш, оюутан, албадын ашигладаг програм хангамж**:

| Програмын нэр | Ашиглаж байгаа програмын нэр | Ашиглаж эхэлсэн он |
|---|---|---|
| Багшийн програм | xCloud | 2015 |
| Санхүүгийн програм | Unicus | 2015 |
| Сургалт бодлого зохицуулалтын алба, хөтөлбөрийн програм | ManxCloud | 2015 |
| Оюутны програм | StudentxCloud | 2015 |
| Номын сангийн програм | Koha програм | 2015 |
| Сервер хамгаалалт | Өөрийн серверийн өрөө | 2011 |
| | xCloud-д байрладаг | 2015 |
| Сүлжээ | Lan, WIFI router | 2005 |
| Wifi сүлжээ | WIFI access point, WIFI router | 2011 |

**Сургалтанд хэрэглэгддэг програм хангамжууд**

| № | Чиглэл | Технологийн нэр | Ашиглах боломжоор хангадаг байдал |
|---|---|---|---|
| 1 | e-learning Оюутны сургалтын системд нэвтрэх хөнгөлөлт | Үүрэн холбооны оператор | Цар тахлын үед Unitel, Mobicom -ийн дугаартай оюутнууд үнэгүй ашигладаг байсан. |
| | | | 2022 оноос Unitel-ийн дугаартай оюутнууд сард 2000 төгрөг төлөөд EDU DATA багцыг идэвхжүүлэн сургуулийнхаа веб хуудас руу 30 хоног дата үнэгүй орох боломжтой. |
| 2 | Цахим хичээл бэлтгэхэд ашиглаж буй программууд | Camtasia, Adobe premiere pro, Adobe after effect програм | Видео хичээл бэлтгэхэд ашигладаг. |
| 3 | Цахим сургалтыг явуулахад ашиглаж буй программууд | Zoom программ | Zoom программын “PRO” багцыг ашигладаг. |
| | | SPSS, STATA программ | Биостатистик, эпидимиологи, судалгааны арга зүй хичээл дээр ашигладаг. |
| | | Google | Gmail, google meet, classroom зэрэг программуудыг ашигладаг. |
| 4 | Удирдлага мэдээллийн систем хөгжүүлэлт | xCloud программ | xCloud системийн хөгжүүлэлт нь сургуулийн удирдлага, сургалтын алба, багш, оюутны санал хүсэлтийн дагуу тогтмол хийгддэг |

**Сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлт, сайжруулалт:**
2021 онд хийгдсэн С.Булганчимэг нарын “Хөдөлмөр засал хөтөлбөрийн чанар хүртээмжийн үнэлгээ” судалгаанд хөдөлмөр заслын ангийн 1-4-р ангийн дамжааны оюутнууд, мөн 2018-2020 оны төгсөгчдийг хамруулсан. Судалгаанаас нийт оролцогчдын 40% нь сургалтын орчин тохилог, 57.1% нь мэргэжлийн ном, сурах бичгийн хүрэлцээ хангалттай, 46.4% нь ур чадварын хичээлийн өрөө тасалгаа хүрэлцээ сайн гэсэн асуултуудад огт нийцэхгүй, нийцэхгүй буюу 1, 2 гэсэн хариулт өгсөн байгаа нь сургалтын орчин нөхцөл хангалтгүй байна гэсэн судалгааны үр дүн дээр тулгуурлаж 2020-2021 оны хичээлийн жилд хөдөлмөр заслын ур чадварын 2 өрөөг тохижуулан, мэргэжлийн гадаад сурах бичиг орчуулан хэвлүүлж, хөдөлмөр заслын 14 үнэлгээг монгол хэлнээ орчуулан хэрэглэх зохиогчийн эрхийн зөвшөөрөл авч, дадлагын хичээлүүдэд ашиглах 17 нэр төрлийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг шинээр худалдан авч сургалтанд ашиглаж эхлэв. Үүнд:

- Хүүхдийн ур чадварын өрөө
- Сургалтын зориулалтаар ашиглах ариун цэврийн өрөө
- Сургалтанд ашиглах 17 нэр төрлийн бүтээгдэхүүн
- “Хөдөлмөр заслын үзэл баримтлалын үндэс” сурах бичиг
- “Тархины харвалтын дараах хөдөлмөр заслын тусламж” гарын авлага
- “Хүний хөдөлмөрийн загвар”-ын 14 төрлийн үнэлгээг орчуулж ашиглах зохиогчийн эрх
- MOMENT төслийн шугамаар физик, хими, эмгэг судлалын хичээлийн тоног төхөөрөмжийг шинэчлэв.

Хөдөлмөр заслын мэргэжилд дадлага маш чухал учир сургалтын хэрэглэглэхүүнтэй онцгойлон танилцав.
Сувилахуйн сургуулиас жил бүр хичээл практикийн зардалд зориулж тодорхой хөрөнгийг төлөвлөдөг.

| Сургалттай холбоотой зардал | 2016-2017 | 2017-2018 | 2018-2019 | 2019-2020 | 2020-2021 |
|---|---|---|---|---|---|
| Оюутны тоо | 20 | 30 | 33 | 30 | 32 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хичээл практикийн зардал | 1,428,357.00 | 144,728.00 | 1,629,935.00 | 1,773,653.00 | 1,406,250.00 |
| Эрдэм шинжилгээний зардал | 375.000 | 733,300.00 | 493,300.00 | 424,760.00 | 625,000.00 |
| Ном хэвлэлийн зардал | 112,107.00 | 222,550.00 | 348,365.00 | 173,252.00 | 244,170.00 |

Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж нь Сувилахуйн сургуулийн ISO 9001/2015 стандартын дагуу явагддаг. Сургалтын үйл ажиллагаатай холбоотой дараах дүрэм журмыг баримтлана. Үүнд:

- Сонгон судлах хичээлийн журам
- Зуны дадлагыг зохион байгуулах журам
- Төгсөлтийн өмнөх сургалтын журам
- Сургалтын технологи хяналтын журам
- Оюутны үнэлгээний журам
- Номын сангийн үйл ажиллагааны журам
- Оюутны үйл ажиллагааны журам
- Багшийн ачааллыг үнэлэх журам

Сувилахуйн сургууль нь бүрэн тоноглогдсон видео бичлэгийн студийг 2021 онд ашиглалтанд оруулж багш нарын видео, цахим хичээлийг хуваарийн дагуу бэлтгэж, шаардлага хангасан е-контентыг сургалтанд ашиглаж байна.
Сувилахуйн сургууль нь бүрэн тоноглогдсон дуу бичлэгийн студийг 2020 онд ашиглалтанд оруулж аудио, видео, цахим хичээлийг хуваарийн дагуу бэлтгэж, шаардлага хангасан е-контентыг сургалтанд ашиглаж байна.

Тараах материал, хэрэглэгдэхүүний хэрэглээ, хүртээмж:

- E-learning, e-erdem системд хичээлийн лекц, семинарын материал, оюутан бие дааж тухай сэдвээр зайлшгүй унших ном, судалгааны өгүүллийг байршуулдаг.
- Хичээлийн хөтөлбөрийг улирал бүрийн эхний 7 хоногт xCloud-д байршуулдаг.
- E-learning, e-erdem, LMS /Learning management system/ -д хичээлийн аудио, видео бичлэгүүдийг байршуулдаг.
- Багш нар e-learning, e-erdem системд дэвшилтэт технологи болох аудио, видео, PPT хичээлүүд, цахим шалгалтын материал бэлтгэж сургалтыг хөтлөн явуулж байна. Оюутнууд e-learning системээр дамжуулан хичээлтэй холбоотой материал, цахим ном зэргийг хүлээн авахаас гадна цахим лекц, семинар, хэлэлцүүлэгт оролцох байдлаар хичээлийг явуулж байна.
- 2020-2021 оны хичээлийн жилд цар тахлын үеийн цахим хичээлд шилжсэнтэй холбоотойгоор 7 хоног бүр цахим хичээлийн тайлан мэдээ гарган, үнэлгээ дүгнэлт хийж холбогдох арга хэмжээг авч байна.

Хөдөлмөр заслын ангид ордог ерөнхий, мэргэжлийн суурь ба мэргэшүүлэх багш нарын цахим хичээл

| № | Хэрэглэгдэхүүний хэлбэрүүд | 2019-2020 | 2020-2021 | 2021-2022 |
|---|---|---|---|---|
| 1 | Цахим видео хичээл | 150 | 300 | 420 |
| 2 | Word, PDF, PPT | 150 | 300 | 420 |
| 3 | Цахим 6 түвшний даалгаврын сан | | | 33 |
| 4 | Цахим ажлын хуудас | | | 33 |
| 5 | Цахим шалгуур хуудас | | | 33 |
| 6 | Цахим хичээлд хамрагдсан оюутны тоо (давхардсан тоогоор) | 54 | 54 | 54 |

**Ярилцлага:**

Төгсөгчидтэй ярилцаж байх үед I, II төгсөлтийн оюутнууд сургалтын хэрэглэгдэхүүн бага байсан хэдий ч дадлагын явцад ихэнхийг нь хийж сурсан нь ажил дээр гарахад их хэрэг болж байсан тухайгаа ярьсан.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Жил бүр бага боловч хичээл практикийн зардал төлөвлөж байгаа нь хөдөлмөр заслын анги, танхимд хэрэглэгдэх хичээлийн хэрэглэгдэхүүнийг баяжуулах боломжтой.
- Сургалтанд хэрэглэх туслах технологийг хийх арга техникийг багш нар өөрсдийн боломжийн хүрээнд оюутнууддаа маш сайн зааж өгч байгаа нь оюутнууд ажлын байран дээр гарахад дөхөм болгож байна.
- Е-контент бэлтгэх суурь баазаа маш сайн тавьсан байсан нь анги, танхимыг үзэх явцад ажиглагдсан.
- Сургалтын хэрэглэгдэхүүнүүд дээр түүний хэрэглээ, хэдэн онд худалдан авсан, хэрэглээний онцлог гэх мэтийг нарийвчлан бичсэн байсан.

**Анхаарах асуудал:**

- Зарим нэг програм хангамжуудын ашиглах эрх дууссан. Түүнийг сунгах ажиллагаа явагдаж байна.
- Сургалтын хэрэглэгдэхүүний нэр төрлийн нэмбэл зүгээр байна.

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

Номын сан:
ЭМШУТНСангийн салбар Сувилахуйн сургуулийн номын сан нь 59.02 м2 талбай бүхий үндсэн болон ойрын фондтой. 162.25 м2 талбай бүхий 88 суудалтай 2 уншлагын танхим, 23 компьютертай цахим 1 уншлагын танхим, 3 номын санчтай ажилладаг.

- Нийт номын фондыг хэлээр ангилбал монгол – 20060, орос - 1186, англи - 1827 нийт 23073 номтой. Үүнээс хөдөлмөр засалч мэргэжлийн 40 нэр төрлийн 157 ширхэг ном байна.
- Цахим хэлбэрээр нийт 1417, үүнээс монгол – 376, англи - 713, бусад хэл дээр 328 номыг уншигчдад хүргэж үйлчилж байна.
- Нэг оюутанд оногдох мэргэжлийн ном – 17.3
- 2015 оноос эхлэн Koha программыг ашиглаж, 23073 ном, сурах бичиг бүртгэгдсэн. Library.mnums.edu.mn:8080 хаягаар нэвтрэн орж хайлт хийх боломжтой.
- Оюутны хэрэгцээнд интернетийн сүлжээ бүхий 23 компьютерийг ашиглаж байна.
- Уншлагын үйлчилгээ батлагдсан цагийн хуваарийн дагуу ажиллахаас гадна оюутнуудад хэрэгцээтэй ном, сурах бичгийг 3-10 хоногийн хугацаатайгаар гэрээр олгож үйлчилдэг. Мөн цахим номыг үйлчилгээг ашиглаж эхэлсэн.
- Сувилахуйн сургуулийн http://e-erdem.mn/course/ хаягаар нэвтэрч өөрийн хэрэгцээт өгүүлэл, бүтээлтэй танилцах боломжтой.

- Хөдөлмөр заслын хөтөлбөрийн чиглэлээр бичигдсэн мэргэжлийн ном, сурах бичигт тавигдах ерөнхий шаардлагыг АШУҮИС-ийн захиралын 2021 оны А/73 дугаар тушаалаар тодорхойлж, нэг стандартад оруулах ажлыг хийж байна.
- 2021 оны 11-р сард ОУ-ын Ротарийн 3450 дүүргийн 9-р бүсийн “Номт” ротари клуб ээлжит оюунлаг төслөөр тохижуулж, судалгаа сургалтандаа ашиглах компьютер, принтерүүдийг хандивласан. Мөн уншлагын таанхимуудыг тохижуулж хаяг шинээр хийсэн.

**2017-2021 онд нэмэгдсэн номын тоо:**

| № | Он | Нэмэгдсэн номын тоо |
|---|---|---|
| 1 | 2017 | 411 |
| 2 | 2018 | 303 |
| 3 | 2019 | 230 |
| 4 | 2020 | 150 |
| 5 | 2021 | 543 |

**2017-2021 онд номын сангаар үйлчлүүлсэн оюутнуудын тоо**

| № | Он | Оюутнуудын тоо |
|---|---|---|
| 1 | 2017 | 22414 |
| 2 | 2018 | 27846 |
| 3 | 2019 | 27090 |
| 4 | 2020 | 9481 |
| 5 | 2021 | 3242 |

**Цахим номын сангийн фонд бүрдүүлсэн нь:**

1. Монгол хэл дээрх ховор сурах бичгийг сканнердаж цахим хэлбэрт хөрвүүлсэн.
2. Нээлттэй эх үүсвэрүүд дээр тулгуурлан уншигчдын эрэлтийг үндэслэн гадаад номыг цахимаар бүрдүүлэв.
3. Олон улсын онлайн мэдээллийн сангуудын тоог нэмэгдүүлэх, сургалт сурталчилгаанд хамрагдаж оюуьан, багш нарт туслалцаа үзүүлдэг.

**Цахим номыг хэлээр ангилах нь**

| № | Цахим номыг хэлээр ялгавал | Тоо |
|---|---|---|
| 1 | Монгол | 376 |
| 2 | Англи | 713 |
| 3 | Бусад | 328 |
| | **Бүгд** | **1417** |

**2017-2021 онд цахим номын сангаар үйлчлүүлсэн оюутнуудын тоо**

| № | Он | Оюутнуудын тоо |
|---|---|---|
| 1 | 2017 | 34427 |
| 2 | 2018 | 44485 |
| 3 | 2019 | 41322 |
| 4 | 2020 | 10240 |
| 5 | 2021 | 5325 |

**Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа**

- 2017-2021 оны хичээлийн жил бүр хөдөлмөр заслын гадаад сурах бичгийг үе шаттайгаар нэмэгдүүлсэн.
- С.Булганчимэг нарын судалгаанд дотоод сурах бичгийн хангамж муу гэж гарсантай уялдуулан 2021-2022 оны хичээлийн жилд Монгол хэл дээрх сурах бичиг нэг, гарын авлага нэгийг бэлтгэж хэвлүүлэх ажил явагдаж байна.

**Хөдөлмөр заслын сургалтанд ашиглаж буй сурах бичиг, гарын авлага**

| № | Сургалтын төлөвлөгөө | Сурах бичиг, гарын авлага (2020-2021) | |
|---|---|---|---|
| | | **Төрөл** | **Тоо** |
| 1 | Ерөнхий суурь | 103 | 5990 |
| 2 | Мэргэжлийн | 40 | 157 |
| 3 | Мэргэшүүлэх | 40 | 210 |
| | **Нийт (давхардсан тоогоор)** | **183** | **6357** |

**Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа**

HINARI хандалтыг 2005 оноос 2014 он хүртэл АШУҮИС-ийн номын санд үнэ төлбөргүй ашиглаж ирсэн. 2014 оноос эхлэн Монгол улсын эдийн засгийн хөгжлөөс шалтгаалж бага төлбөртэй ашиглах болсон. 2014 онд 1000 ам.доллар, 2015 онд 1500 ам.доллар төлсөн байна. БСШУЯ-ны төслөөр Springer, Ensco Host мэдээллийн сангуулыг 1 жилийн хугацаатай туршилтаар ашиглаж байна.

**Ашиглаж буй мэдээллийн сангууд:**

| Сэтгүүл | Тоо | Сэтгүүл | Тоо | Сэтгүүл | Тоо |
|---|---|---|---|---|---|
| Elsevier Science | 21686 | JAMA | 19 | HEIJM | |
| John Wiley Sons | 1404 | BIO MED Central | 7 | Wolters Kluwer | 445 |
| Thieme | 88 | HINDAWI | 373 | Karger | 13 |
| Sage | 672 | Springer | 216 | Oxford University Press | 172 |
| BMJ | 63 | Taylor Francis | 1048 | Cochrane Library | |
| Lancet | 9 | Springer Link | 1841 | Scopus | |
| Ebsco-Host | | | | | |

**Цахим мэдээллийн сан**

АШУҮИС-аас HINARI ашиглах эрхийн төлбөр болох 1500 ам.долларыг төлж, HINARI ашиглах заавар, зөвлөгөөг уншигчдад тогтмол өгч, шаардлагатай тохиолдолд хэрэгцээт мэдээллийг татаж өгсөн. 2021 онд HINARI онлайн мэдээллийн санд АШУҮИС-ийн багш судлаачид 22036 удаан хандсан байна. 2021 онд шинээр 143 хэрэглэгч бүртгэж нийт хэрэглэгчдийн тоо 777 хүрчээ. HINARI 8900 орчим хурлын материал, илтгэл, өгүүлэл, 21000 орчим сэтгүүл, 70000 орчим номтой.
Хичээлийн хөтөлбөрийн үндсэн сурах бичиг болон нэмэлт материалуудын хүрээнд ашиглаж буй нээлттэй цахим эх сурвалжуудыг тусган сургалтанд ашиглаж байна. Дараах 10 эх сурвалжийг номын санд тогтмол ашиглаж байна. Үүнд:

1. https://login.research4life.org/tacgw/login.cshtml
2. https://www.cochranelibrary.com/
3. https://pubmed.ncbi.nlm.nih.gov/
4. https://www.nejm.org/
5. https://extranet.who.int.rhl
6. http://www.bioline.org.br/
7. http://www.freebooks4doctors.com/
8. http://www.freemedicaljournald.com/
9. https://books.openedition.org/
10. https://www.openedition.org/catalgoue-journals

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Номын сангийн ангилал олон улсын ангиллаар (DDC) явагддаг.
  - Ном ариутгах шинэ тоног төхөөрөмжтэй.
  - Цахимаар болон уншиж суух танхимтай.
  - “Хөдөлмөр заслын үзэл баримтлалын үндэс” сурах бичиг монгол хэлээр гарсан нь оюутнуудад чухал эс үүсвэр болж байна.

**Анхаарах асуудал:**

- Хөдөлмөр заслын олон англи ном, гарын авлага байна. Монгол хэлрүү үе шаттай орчуулж хэрэглээнд оруулах шаардлагатай.

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

**4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**
Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

Бие, бялдар судлалын тэнхим нь нийт 8 багшийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Хөдөлмөр заслын хичээлийн сэдэв, агуулгын давхардлыг арилгах, уялдааг сайжруулах, мэргэжилтэний цогц чадамжийг боловсруулж Сувилахуйн сургуулийн сургалтын хөтөлбөрийн дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Тус хурлаас гарсан шийдвэрийн дагуу АШУҮИС-ийн нэр томьёоны хурлаар хөдөлмөр засалын бакалаврын хөтөлбөрт ашиглагдаж байгаа нэр, томьёоны орчуулгыг хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.

Сургалтын үйл ажиллагаа эрхлэх явцдаа: БСШУС-ын A/174 тушаалын хавсралт "Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага", "Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам", "Суралцагчийг үнэлэх журам", "Сургалтын технологи, хяналтын үлгэрчилсэн журам", АШУҮИС-ийн хэмжээнд мөрдөх, биелүүлэх "Багшийн алтан дүрэм", "Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам" зэрэг холбогдох дүрэм, журмуудыг мөрдөж хэрэгжүүлж байна.

Бие, бялдар судлалын тэнхмийн хөгжлийн стратеги төлөвлөгөөний биелэлтийг 2020 хүртлэхийг дүгнэж үзэхэд орчин нөхцөл, хэрэглэгдэхүүнийг сайжруулахаас бусад 100% биелэлтэй байна. Орчин нөхцөл сургалтын хэрэглэгдэхүүнийг үе шаттай нэмэгдүүлж байгаа нь нотлогдож байгаа бөгөөд цаашид судалгаа шинжилгээний багаж тоног төхөөрөмжийг нэмэглүүлэх хэрэгцээг 2020-2025 оны тэнхмийн стратеги төлөвлөгөөндаа тусгасан байна.

АШУҮИС-ийн хэмжээнд оюутны санал гомдолыг цахим хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэн, ИСУМС-ийг хөгжүүлэн ажиллаж байна.

ББСТ-ийн сүүлийн 5 жилийн жил бүрийн төлөвлөгөө тайлантай танилцахад төлөвлөгөөний биелэлт 100% байна.

АШУҮИС-ийн багш нар өөрийн заадаг хичээлийн тэмдэглэл, сорилыг цахим хэлбэрээр бэлтгэн цахим сургалтын аргыг нэвтрүүлжээ. 2021 онд тус хөтөлбөрийн бүх лекцүүд 100% цахимд шилжсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургуулийн хөтөлбөрийн дэд хороогоор хөдөлмөр засал бакалаврын сургалтын хөтөлбөрөө хэлэлцүүлсэн байна.
- Сургуулийн захиралын тушаалаар хөтөлбөрийн хөгжил хариуцсан ажлын хэсэг байгуулагдан амжилттай ажиллаж байна.

- АШУҮИС-ийн хөгжлийн бодлого 2030, Сувилахуйн сургуулийн хөгжлийн бодлого 2015-2024 онд тулгуурлан хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь 5 жилийн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй.
- Их сургуулийн цахим удирдлагын системийн хөгжүүлэлтийг тогтмол хийдэг.

**Анхаарах асуудал:**

- Хөдөлмөр засалч мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийн урт хугацааны үнэлгээний шалгуурыг гаргахдаа тус мэргэжлээр элсэж орсон оюутны тоо, төгссөн хөдөлгөөн засалчийн тоон дээр тулгуурлаж бодиттой гаргах.
- Хөдөлмөр засалч мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийг олон нийтэд сурталчилах ажлыг эрчимжүүлэх

**Зөвлөмж:**

- Хөдөлмөр засалч мэргэжлийн бакалаврын хөтөлбөрийг олон нийтэд сурталчилах ажилд бизнесийн маркетингийн аргыг ашиглах

**4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

Гадаад, дотоодын хамтын ажиллагааны гэрээ, төсөл хөтөлбөрүүд, багш оюутнууд гадаадын их дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлсэн тайлантай танилцлаа.

Япон улсын Гунма их сургууль, Швейцарийн Цүрихийн их сургуультай хамтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

Японы Гунма их сургуулиас давхардсан тоогоор сүүлийн 5 жилд 5 багш уригдан ирж, хөдөлмөр заслын хичээлийг Сувилахуйн сургуулийн хөдөлмөр заслын багш нартай хамтран орсон байна.

Сувилахуйн сургуулийн Бие, бялдар судлалын тэнхимээс Гунмагийн сургуульд хөдөлмөр заслын 2 багш, 10 оюутан төгсөлтийн өмнөх эрт үеийн танилцах дадлагыг хийсэн байна. 2021 онд Хөдөлмөр засалч Б.Мөнхбаясгалан Япон улсын засгийн газрын тэтгэлгээр магистрантур докторантурт суралцаж байна.

Швейцарийн Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны Их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулиас 3 багш ирж хөдөлмөр заслын багш нартай хамтран сургалт зохион байгуулж, хөтөлбөрийн оролцогч талуудтай уулзалт хийсэн байна.

Сувилахуйн сургуулийн Бие, бялдар судлалын тэнхимийн хөдөлмөр заслын 2 багш давтагдсан тоогоор 5 удаа, 5 оюутан 14-21 хоногийн хугацаатай Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны Их сургуульд хөдөлмөр заслын олон улсын багш, оюутнуудын өвлийн сургалтанд хамрагдсан байна.

Багш, суралцагч солилцооны хөтөлбөрийг зохион байгуулж оролцох оюутныг шалгаруулахдаа АШУҮИС-ийн оюутны алба, Сувилахуйн сургуулийн захиргаа, Бие бялдар судлалын тэнхим хамтран 2 үе шаттай зохион байгуулдаг. Сургуулийн дотоод сүлжээгээр дамжуулан хөдөлмөр заслын оюутнуудад оюутан солилцоо болон шалгуур үзүүлэлтийн тухай мэдээллийг түгээдэг.

- 1-р шатанд тодорхой сэдвийн хүрээнд эссэ бичих даалгаврыг оюутнуудад өгдөг. Шалгаруулалтад ирсэн эссэг оюутны албаны төлөөлөл, Биe бялдар судлалын тэнхимийн багш нарын бүрэлдхүүнтэй багийн гишүүн бүр уншиж үнэлгээг өгнө.
- 2-р шатанд шалгаруулалтад оролцож буй оюутнууд англи хэлний бичгийн орчуулга хийж шалгагч багийнхантай англи хэлээр ярилцлагад орно. Хоёр шатны нийлбэр оноогоор тухайн хамгийн өндөр оноо авсан оюутныг квотод тохируулан сонгодог.

Хүн ардад эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх сургалтуудыг тогтмол явуулж байна. 2014 оноос дэлхийн хөдөлмөр заслын өдрийг зохион байгуулж байна. 2019 онд Сүхбаатарын талбайд Хөдөлмөр засал мэргэжлийг сурталчилах өдөрлөгийг зохион байгуулсан байна.

Монголын Хөдөлмөр заслын холбоо нь хүн амын эрүүл мэндийг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах талаар төр, олон нийт, төрийн бус байгууллагатай хамтран сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлтэй, төрийн бус байгууллага юм. Тус холбоо нь 2014 онд 14 гишүүнтэйгээр байгуулагдаж байсан бөгөөд 2022 оны 1-р сарын байдлаар 66 гишүүнтэй болж өргөжжээ. Монголын Хөдөлмөр заслын холбоо нь 2021 оны 1-р сард Хөдөлмөр заслын Дэлхийн холбооны дэд гишүүн болсон байна.

Монголын хөдөлмөр засалчдын холбоо, Японы Гунма их сургуультай хамтран хөдөлмөр засалч нарт “Стресс менежмент”, “Танин мэдэхүйн алдагдалын үеийн хөдөлмөр засал” “Танин мэдэхүйн алдагдалын үеийн хөдөлмөр засал-ой санамж” сэдвүүдээр төгсөлтийн дараах цахим сургалтыг 2021 онд тус тус зохион байгуулав. Нийт төгсөгч нар бүгд хамрагдсан байна.

“Хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал” сэдэвт цахим сургалт болж байна Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа L3605/G9191: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд “Хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал” сэдэвт цахим сургалтыг 2022 оны 1 дүгээр сарын 11-нээс 3 дугаар сарын 03-ны хооронд зохион байгуулж байна. Энэхүү сургалтанд 20 хөдөлмөр засалч хамрагдсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Японы Гунма их сургууль, Шейвцарын Цүрихийн их сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй. Төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын үйл ажиллагаа тогтмол явагдаж байна.
- Дотоод хамтын ажиллагаатай байгуулгуудтай гэрээтэй.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь олон улсын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд манлайлан оролцож байна. (ДЭМБ-аас хэрэгжүүлж буй сэргээн засах сэргээн засах хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулах төсөл, Амьдралын үргэлжлэл-нугасны гэмтэлтэй үйлчлүүлэгчийг өдөр тутмын үйл ажиллагааг сайжруулах төсөл, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй Дархан, Дундговь, Архангай, Хөвсгөл, Ховд, Дорнод аймгуудад сэргээн засах хүүхдийн төв байгуулах төслийн хүрээнд тухайн аймгуудын сэргээн засах төвийн хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч бэлтгэх сургалтыг хариуцан явуулж байна.)
- Японы Гунма их сургууль, Шейвцарын Цүрихийн их сургууль руу оюутан солилцооны хөтөлбөрийг явуулахдаа нээлттэй сонгон шалгуулалт хийсэн байна. Уг шалгаруулалтын 3 үе шаттай явуулдаг бөгөөд нэгдүгээр 500-1000 үгтэй эссэ бичүүлнэ, хоёрдугаарт

мэргэжлийн кэйс тохиолдлыг англи хэл дээр өгч ажиллуулах, гуравдугаарт англи хэл дээр ярилцлага хийдэг. Дээрх 3-н шалгаруулалтын нийлбэр дүнгээр оюутныг сонгодог байна.

- Гадаад хамтын ажиллагааны үр дүнд мэргэжлийн чиглэлийн 14 үнэлгээг албан ёсны эрхтэй ашиглаж байна. Хөдөлмөр заслын 2 магистрант 2 үнэлгээг орчуулан монгол хувилбарын хүчин төгөлдөр, найдвартай байдлын судалгааг хийж байна.
- Хөдөлмөр заслын анхны сурах бичиг хэвлэгдэн гарсан байна.
- Монголын хөдөлмөр заслын холбооны үйл ажиллагаа тогтмолжсон, 2021 онд Дэлхийн хөдөлмөр заслын холбооны дэд гишүүн болсон. Дэлхийн хөдөлмөр заслын холбоотой тогтмол хамтын ажиллагаатай.
- Уг хөтөлбөрийн магистрын сургалт эхэлсэн.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим, монголын хөдөлмөр заслын холбоотой хамтран гадны их дээд сургуулиудаас төгсөлтийн дараах цахим сургалтуудыг зохион байгуулсан.

**Анхаарах асуудал:**

- Дотоод хамтын ажиллагаа нь зөвхөн УБ хотын төвийн 6 дүүргээр хязгаарлагдаж байна.

**Зөвлөмж:**

- Хөдөө орон нутгийн хөдөлгөөний чадвар алдсан хүмүүст хөдөлмөр засал эмчилгээний шаардлага, хэрэгцээ их байгаа тул хөдөө орон нутгийн эрүүл мэндийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй байна. Ингэснээр хөдөлмөр засал мэргэжлийн үр шимийг хүртсэн иргэдэд дамжуулж мэргэжлээ сурталчилах боломжтой.

### 4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

**Илрэл нотолгоо:**

АШУҮИС-ийн хэмжээнд Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол улсын хуулийн дагуу төвлөрүүлэн захирч, зарцуулах журмаар үйл ажиллагаа явагдаж байгаа нь Монгол улсын санхүүгийн талаар баримтлаж байгаа хууль эрхийн орчинд нийцнэ. АШУҮИС-ийн хэмжээнд мөрдөгдөж байгаа Хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв санхүүгийн эх үүсвэрийг олон талтай болгох, биеэ даасан байдлыг сайжруулах талаар заалт оруулсан байна. АШУҮИСийн захиргаа бүрэлдэхүүний ба харьяа сургуулийн жилийн төсвийг нэгжээс авч, аль болох нэгж байгууллагын саналыг үндэслэн төсөв зохиох санхүүжилт, хуваарилалтыг хийх талаар санаачилга гарган ажилласан байна.

*Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүн, 2021-2022 он*

| Үзүүлэлт | I курс | II курс | III курс | IY курс |
|---|---|---|---|---|
| Оюутны дундаж тоо | 33 | 36 | 36 | 32 |
| Сургалтын төлбөрийн хэмжээ | 2.475.000 | 2.887.500 | 2.250.000 | 1.950.000 |
| Нэг оюутанд ноогдох дундаж зардал /урсгал зардалд харьцуулсан/ | 643.3 | 1,357.8 | 1,181.6 | 931,3 |
| Зөрүү | 412.500 | | 300.000 | |

Төсвийг сургалтын материал, ур чадварын тоног төхөөрөмж худалдан авах, оюутны хөгжилд зориулсан үйл ажиллагаанд зарцуулсанг тайлан, илрэл нотолгооноос харж байна.

Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд орчин үеийн техник хэрэгсэл бүхий лабораториуд байгуулах, багш нарыг хөгжүүлэх сургалтуудад хамруулах, хөтөлбөрийг дотоодод болон олон улсад магадлан итгэмжлүүлэх гэх мэтчилэн хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсвийг жилийн урьдчилсан төсөвт хөтөлбөрийн багш нарын зүгээс хэлэлцэж төсөл бичиж оруулж, шат дараатайгаар хэрэгжиж ирсэн байгаа нь тайланд бичигдсэн байна.

Сургалтын ажлын тогтмол зардлыг төрөөс хариуцан жил бүр тогтмол санхүүжүүлдэг. Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтад “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын дагуу “Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээл”-тэй оюутнуудын сургалтын төлбөрийг хөнгөлдөг ба тус жилүүдэд Хөдөлмөр засалчийн мэргэжилтэн бэлтгэж буй салбарын 2 оюутан энэ тэтгэлэгт хамрагдсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа L3605/G9191: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд олон улсын хэмжээнд хүүхдийн сэргээн засах практикт өргөн ашиглагддаг (Хүүхдийн үнэлгээ BOT 2- (Bruininks-Oseretsky Test of Motor Proficiency Second Edition) 1028 фунт стерлинг, SPM&SPM-P (Sensory Processing Measure) 803 фунт стерлинг, PDMS2 (Peabody Developmental Motor Scale) 837 америк долларын үнэтэй) гурван төрлийн үнэлгээний багцыг сургалтанд ашиглах албан ёсны зөвшөөрөлтэйгөөр хандиваар хүлээн авсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутнуудын сургалтын төлбөрийн тодорхой хувь нь тухайн мэргэжлийн хичээлийн орчин нөхцөл, хэрэглэгдэхүүнийг сайжруулахад зарцуулж байна.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлж сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулсан байна.
- Хөтөлбөрийн санхүүжилтийг бүрдүүлэх, төсөв хувиарлах, зарцуулах үйл ажиллагаа Монгол улсын санхүү бүртгэлийн хуулийн нөхцөлд зөрчилгүй явагдаж байна.

**Анхаарах асуудал:**

- Багш, ажилчдын нийгмийн асуудлыг шийдэхэд хувь нэмэр болохуйц санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудлыг анхаарах

**Зөвлөмж:**

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай зөвлөн туслах, мэргэжил арга өгөхХөдөлмөр заслын төлбөртэй үйлчилгээ үзүүлж иргэдэд илүүтэй хүрэх замаар төсөвт хувь нэмэр оруулах боломжийг судлах.

### 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

Нийт 5 нотлох баримттай танилцлаа. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь үйл ажиллагаа болон элсэлттэй холбоотой мэдээллүүдийг сургуулийн албан ёсны фэйсбүүк пэйж, хөдөлмөр заслын холбооны пэйж, АШУҮИС-ийн элсэлтийн хуудсуудаар дамжуулж мэдээллсэн байна. Хөдөлмөр засалч мэргэжлийн тухай олон нийтийн зурагт, радио, подкастууд түгээн ажилласан баримттай танилцлаа.

Бие бялдар судлалын тэнхим нь жил бүр ажил олгогчид, төгсөгч, оюутнуудаас тогтмол судалгааны дүгнэлттэй танилцлаа. Мөн төр хувийн хэвшлийн төрөлжсөн, нэгдсэн эмнэлгүүдийн удирдлага, алба нэгжийн дарга нартай уулзалт зохион байгуулж, мэргэжлийн онцлог, мөн чанарыг таниулж тэдний санал зөвлөгөөг авч ажилласан байна.

Олон нийтийг үнэн зөв, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр хангахын тулд АШУҮИС-ийн цахим хуудсанд Бие Бялдар Судлалын тэнхимийн танилцуулга, багш нарын танилцуулга болон үйл ажиллагааны мэдээллийг байршуулж тогтмол шинэчлэн идэвхтэй ажиллаж байгааг сайтаас нь харлаа.

Хөдөлмөр засалч мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн талаар телевиз, АШУҮИС-н маркетингийн албанаас сургуулийн албан ёсны сайт болон фэйсбүк хуудас, Сувилахуйн сургууль, АШУҮИС элсэлт гэх мэт албан ёсны групп-д мэргэжлийн тухай мэдээллийг байршуулан ажиллаж байгааг мэдээллийн эх сурвалжаас нь үзлээ.

Монголын хөдөлмөр засалчдын холбооны фэйсбүүк хуудас (Хөдөлмөр засалчдын Монголын холбоо | Facebook), бусад мэдээллийн хэрэгслийг ашиглан сурталчлах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан байна.

Хөдөлмөр заслын чиглэлийн мэргэжил таниулах, ард иргэдэд зориулсан сургалтууд тогтмолжсон байна. Жишээ нь хамгийн сүүлийн үйл ажиллагаанаас дараах зүйлүүдийг онцолж байна.

- Монголын хөдөлмөр засалчдын холбоотой хамтран мэргэжлийг нийгэмд таниулах ажлыг тогтмол зохион байгуулсан байна.
- Монголын хөдөлмөр засалчдын холбоотой хамтран элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилготой БШУЯ, ХНХЯ, 21 аймгийн засаг дарга, эрүүл мэндийн газрын дарга нарт тухайн мэргэжлийн хэрэгцээ шаардлага, нийгэмд үзүүлэх үр нөлөөний талаар албан бичиг хүсэлтүүдийг илгээн ажилласан байна.
- Жил бүрийн 10 дугаар сарын 27-нд “Дэлхийн хөдөлмөр засалч нарын өдөр”-ийг Монгол улсад анх 2014 оноос хойш тэмдэглэж ирсэн. Тухайн өдрөөр улсын лавлагаа шатлалын, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдээр хөдөлмөр засалч мэргэжлийг сурталчлан сургалт болон хөдөлмөр заслын эмчилгээнд ашиглагддаг гардан үйлдлийн техникийн сургалт явуулсан тухай нотлох баримт байгаатай танилцлаа.
- МҮОНТВ-ийн Эрүүл мэндийн 120/80 нэвтрүүлэгт “Хөдөлмөр засал” -ийн тухай тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгч, багш, оюутан, төгсөгчдийн хамтаар оролцсон байна.
- Гэр бүлийн радио 104.5 – Бидний дэргэдэх гайхамшиг нэвтрүүлэгт орж “Хөдөлмөр засал” -ийн танилцуулсан баримттай танилцлаа.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сургууль элсэлтэнд зориулсан албан ёсны мэдээлэлийн сувагтай байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь албан ёсны мэдээлэлийн сувагтай байна.
- АШУҮИС нь маркетинг албатай бөгөөд мэргэжлийн танилцуулга боршур, подкастуудыг тогтмол хийдэг.

- Хөдөлмөр заслын өдрийг 2014 оноос жил бүр 10 сарын 27-ны өдөр тэмдэглэж байгаа бөгөөд тухай өдрөөр мэргэжлийг олон нийтэд танилцуулах ажлыг тогтмол хийж байна. 2019 онд Сүхбаатарын талбайд хөдөлмөр заслын мэргэжлийг сурталчилах ажлыг зохион байгуулсан тухай тайлантай танилцлаа.
- Тайлангийн үнэлгээг хийх явцад төлөөлөл болгож 9 ажил олгогчидтой уулзалт зохион байгуулахад Хөдөлмөр засалч мэргэжилтэнд сэтгэл хангалуун байлаа.

**Анхаарах асуудал:**

- Мэргэжил суртачилах маркетингийг өргөжүүлэх

**Зөвлөмж:**

- Мэргэжил суртачилах маркетингийг хөдөө орон нутаг руу чиглүүлэх
- ЕБС-ийн төгсөх ангийн хүүхдэд мэргэжлийн баримжаа олгох хичээлд “Хөдөлмөр засал” мэргэжлийн тухай орох- үүнийг ЭМЯ, БШУЯ-ны бодлогод тусгах
- Хөдөлмөр засал мэргэжлийн бакалаврын хөтөлбөр нь Япон улсын Гунма их сургууль, Швейцарийн Цүрихийн их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд оюутан солилцуулах хөтөлбөртэй гэдэг сурталчилгааг ЕБС-ийг төгсөж байгаа хүүхдүүдийн эх, эцэг, асран хамгаалагчдад түлхүү өгөх.
- Хөдөлмөр засалчийн хийсэн эмчилгээний үр дүнд хөдөлгөөнийн чадвар эрчимтэй сэргэж, хурдан хугацаанд бие даан амьдарч, ажил хөдөлмөртөө эргэн орсон хүмүүсийн сэтгэгдлийг авсан видео бичлэг, контент хэлбэрээр сурталчилгааг хийх зэрэг маркетингийн ажлыг явуулах

**4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

**Илрэл нотолгоо:**

АШУҮИС нь тогтмол цахим сонин гаргадаг бөгөөд бүх тэнхим, хөтөлбөрүүд сонинд мэдээлэлээ нээлттэй нийтлүүлдэг.

Бие, бялдар судлалын тэнхимийн хөдөлмөр заслын багш М.Эрдэнэцэцэг “Хөдөлмөр заслын үндсэн сурах бичиг” бичих төлөвлөгөөг 2021 оны эхнээс боловсруулан судалгаа хийсний үр дүнд G.Kielhofner-ийн Conceptual foundations of occupational therapy номыг орчуулж хэвлэх шийдвэрт хүрч зохиогчийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аван номыг орчуулаад хэвлэн гаргасан. Мөн “Routledge International Handbook of Occupational Therapy” хэмээх ном бүтээхэд оролцохоор гэрээ байгуулсны дагуу номын нэг бүлгийг бичиж тогтоосон цаг хугацаанд нь илгээсэн байна.

Бие, бялдар судлалын тэнхимийн хөдөлмөр заслын багш С.Булганчимэг “Дээд мөчдийн эмгэгийн үеийн хөдөлмөр засал, “Тархины харвалтын дараах хөдөлмөр засал эмчилгээ” зэрэг цахим гарын авлагуудыг боловсруулсан байна.

Сургуулийн албан ёсны вэйб сайт, сургуулийн албан цахим хуудсууд, албан ёсны хаалттай группүүд, сургуулийн мэйл хаяг, Монголын хөдөлмөр заслын холбооны фэйсбүк хуудас. Сургуулийн вэйб үйл ажиллагаа нь тогтмолжсон байна. (http://www.mnums.edu.mn)

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлмөр заслын анхны монгол сурах бичиг хэвлэгдэн гарсан.
- Сэргээн засах анагаах ухаан сэтгүүл тогтмол хэвлэгдэн гарч байна.
- Бие, бялдар судлалын тэнхимийн хөдөлмөр заслын багш С. Булганчимэг “Дээд мөчдийн эмгэгийн үеийн хөдөлмөр засал”, “Тархины харвалтын дараах хөдөлмөр засал эмчилгээ” зэрэг цахим гарын авлагуудыг боловсруулсан байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээж ажиллаж байна.
- Сургуулийн албан ёсны вэйб сайтын үйл ажиллагаа тогтмолжсон байна.
- Мэдээллийн олон талт сувгийг ашигладаг.

**Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн монгол хэл дээрх сурах бичиг дутмаг.
- Орчуулгын номонд дээрх зарим жишээг монгол ахуй, хөдөлмөр рүү оруулагүй байна.

**Зөвлөмж:**

- Мэргэжлийн монгол хэл дээрх сурах бичгийг үе шаттай нэмэгдүүлэх

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

Тус хөтөлбөрт элсэгчдийг зохих журмын дагуу, ил тод зохион байгуулдаг нь жил бүрийн элсэлтийн шалгалтын журмын заалтууд, тушаалууд, тайлан, оюутанд зориулсан хөтөч, веб сайтад байршсан мэдээллүүд зэргээр нотлогдож байна.

Дараах нотолгоонуудаар нотлогдсон:

- www.mnums.edu.mn вэб сайтын элсэлт цэсэнд байрласан “Элсэлтийн журам, элсэлттэй холбоотой нэмэлт мэдээлэл”
- Шинээр элсэгчдэд зориулсан 07 хоногийн “Удиртгал хичээл”-ийг хуваарийн дагуу зохион байгуулдаг байдал
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 3 сарын 31-ийн өдрийн А/68 тоот “АШУҮИС-ийн Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам батлах тухай” тушаал
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 9 сарын 8-ны А/177 тоот “Оюутан элсүүлэх тухай” тушаал
- АШУҮИС-ийн захирлын 2020 оны 6 сарын 12-ны өдрийн А/146 тоот “Төгсөлтийн өмнөх сургалтад 2020-2021 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх журам батлах тухай” тушаал
- АШУҮИС-ийн захирлын 2020 оны 9сарын 14-ний А/198 тоот “2020-2021” онд оюутан элсүүлэх тухай” тушаал
- АШУҮИС-ийн захирлын 2019 оны 4 сарын 22-ны өдрийн А/116 тоот “АШУҮИС-д оюутан элсүүлэх журам батлах тухай” тушаал

- АШУҮИС-ийн захирлын “Оюутан элсүүлэх тухай” тушаал – 2020, 2019, 2018, 2017, 2016
- АШУҮИС-д 2019-2020 оны хичээлийн жилийн 1 дамжаанд элсэн сурагчдад зориулсан мэргэжлийн чиг баримжаа олгох “Удиртгал” 07 хоногийн хичээлийн хуваарь
- Удиртгал хичээлийн холбоос 2020, 2021
- АШУҮИС-ийн Оюутны хөтөч-2019, Сувилахуйн сургуулийн Оюутны хөтөч-2022, “Хөдөлмөр засал” хөтөлбөрийн оюутны хөтөч-2021

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- 2020-2021 оны хичээлийн жилээс өмнө бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтыг **хими, биологи** хичээлүүдээр элсэлтийн ерөнхий шалгалт өгч, босго оноонд хүрч, элсэхээр хүсэлт гаргасан элсэгчдийг элсүүлдэг байсан. 2021-2022 оны хичээлийн жилээс **математик, физик, англи хэл, нийгмийн тухай мэдлэг** хичээлүүдээр элсэлтийн ерөнхий шалгалт өгч босго оноо хангасан элсэхийг хүсэгчдийг элсүүлдэг болсон нь “Хөдөлмөр засал” хөтбөлбөрийн онцлогт нийцсэн олон талын суурь мэдлэг бүхий элсэгч элсүүлэх боломжийг бий болгосон байна.
- АШУҮИС-ийн “Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам”-д заасны дагуу дээд боловсролтой иргэн: 2.8 ба түүнээс дээш голч дүнтэй, хоёр дахь дээд боловсрол эзэмшихийг хүссэн тохиолдолд тухайн иргэний хүсэлтийн дагуу шаардлага хангасан элсэхийг хүсэгчдийг хөдөлмөр засалч хөтөлбөрт элсүүлэн суралцуулдаг нь онцлог байна. Тус заалтын дагуу 5 оюутан хөдөлмөр заслыг хоёр дахь мэргэжлээ болгон сонгон суралцаж байна. Ингэхдээ өмнө судалсан хичээлээс дүйцүүлэн тооцож болох хичээлийг АШУҮИС-ийн захирлын 2016.12.16-ны өдрийн А/132 тоот тушаал “Багц цаг дүйцүүлэн тооцох журам”-аар зохицуулж байгаад 2019.09.13-ны өдрийн А/290 тоот тушаалаар уг журамд нэмэлт өөрлөлт оруулсны дагууд өмнө судалсан хичээлийг дүйцүүлэн тооцдог болсон нь онцлог байв.

**Анхаарах асуудал:**

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтанд хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан хэдий ч Монгол оронд эрэлт хэрэгцээ өндөртэй байгаа тус мэргэжлээр элсэн суралцагчдын тоог нэмэгдүүлэх тал дээр холбогдох яам, төр засгийн зүгээс авч хэрэгжүүлэх **бодлогын дэмжлэг зайлшгүй** шаардлагатай.

**Зөвлөмж:**

- Холбогдох яамдын сайдын Төрийн захиргааны удирдлагын стратеги төлөвлөлтөнд Улаанбаатар хот болон орон нутагт шаардлагатай “Хөдөлмөр засалч” мэргэжилтний хүний нөөцийг бэлтгэх талаар тусгуулах

### 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

Оюутны клуб, оюутанд үйлчлэх алба, оюутны зөвлөл, хөдөлмөрийн бирж зэрэг байгууллагууд нь жил бүр ажлын төлөвлөгөө гаргаж албажуулан ажилладаг нь “Оюутны хөгжил хариуцсан ажлын хэсгийн төлөвлөгөө, тайлан, зөвлөх багшийн ажлын үр дүн,

оюутны эрүүл мэндийг дэмжих төвийн төлөвлөгөө, тайлан, ажлын үйл явц болон уулзалт ярилцлага" зэргээс тодорхой харагдаж байна.

Дараах нотолгоонуудаар нотлогдсон:

- Хөдөлмөр заслын сургалтын хөтөлбөрийг үнэлсэн оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Сувилахуйн сургуулийн оюутныг дэмжих хөгжүүлэх "Эрүүл оршихуй" хөтөлбөр
- Оюутны хөгжил хариуцсан ажлын хэсгийн төлөвлөгөө
- Сувилахуйн сургуулийн Оюутны хөгжил хариуцсан ажлын хэсгийн тайлан
- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 9-р сарын 17-ны өдрийн А/187 тоот тушаал / "Оюутан хөгжил" хөтөлбөр
- Сувилахуйн сургуулийн захирлын 2021 оны 9-р сарын 6-ны өдрийн А/17 тоот тушаал / Ажлын хэсэг байгуулах тухай
- Сувилахуйн сургуулийн захирлын 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/26 тоот тушаал / Зөвлөх багш томилох тухай
- Сувилахуйн сургуулийн захирлын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/28 тоот тушаал / Оюутны эрүүл мэндийг дэмжих төв
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл (L3605/G9191-MON)-ийн хүрээнд хийгдсэн "Хүүхдийн хөдөлгөөн засал, хөдөлмөр заслын цахим сургалт"-ын тайлан
- Сувилахуйн сургуулийн хангамж үйлчилгээний газрын үйл ажиллагааны тайлан, 2021
- Оюуны галлерейн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Сувилахуйн сургуулийн номын сангийн дүрэм, журам
- Харилцааны ур чадвар, Монгол ёс, соёл, зан заншил, Хүний хөгжил хичээлийн хөтөлбөр
- "Эрхэм хүн байя" цуврал сургалтын төлөвлөгөө, тайлан
- Оюутан хөгжил хөтөлбөрийн "Үлгэрлэгч оюутан" хөтөлбөрийн лекц
- Эх оронч оюутан дэд хөтөлбөрийн Оюутан цэрэг - Нэг өдрийн сургалт, сурталчилгааны арга хэмжээ
- "Хувь хүний хөгжил" цуврал сургалтын төлөвлөгөө, тайлан
- Сувилахуйн сургууль болон Дуурь бүжгийн эрдмийн театрын хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээ
- "Оюунлаг залуус" оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2018, 2020
- "Чадварлаг оюутан" ОЭШ-ний хурал, 2020
- "Ирээдүйн үнэ цэнэ-Шинэ үеийн судлаачид" ОЭШХ-ын эмтхэтгэл, 2022
- Төсөлд суурилсан суралцахуйн хөтөлбөр

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллаж, орон нутгийн 6 аймагт баригдаж буй "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөгжлийн төв"-д ажиллах шаардлагатай хөдөлмөр засалч мэргэжилтний хүний нөөцийг бүрдүүлэхэд

чиглэсэн тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх гэж байгаа нь бодлогын түвшний онцлог үйл ажиллагаа болсон байна.

- Түгээмэл хөгжил, Энэрлийн түүчээ гэх мэт ТББ-уудтай хамтран дадлагажингаа суралцах боломжтой төсөл хэрэгжүүлдэг нь оюутны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна.
- Хөдөлмөр заслын багш, оюутнууд "Зориг сан"-ийн Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөрт оролцон, Австралийн хөдөлмөр засалч мэргэжилтнүүдтэй хамтран туслах хэрэгсэл, тэргэнцэр угсрах, тохируулах чиглэлээр төслийн үйл ажиллагаанд оролцсон нь практик ур чадвараа нэмэгдүүлэх чухал ажил болсон байна.
- Оюутнууд суралцах хугацаандаа төсөл бичиж, төсөл нь ADB-ийн санхүүгийн дэмжлэг авахаар шалгарч, "Амьдралын үргэлжлэл" төслийг амжилттай хэрэгжүүлэн, төслийн үр дүнд нугасны гэмтэлтэй хүмүүсийг бие даан амьдрах чадварт сурган, үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг дээшлүүлэн, сэтгэл ханамжтай амьдрахад чухал дэмжлэг үзүүлэн, төсөл хэрэгжүүлэнгээ суралцсан нь маш үр дүнтэй ажил болсон байна.

**Анхаарах асуудал:**

- Оюутны байгууллагын санхүүжилтийг тухайн жилийн оюутны төлбөрийн тодорхой хувиар, нийт оюутны тоонд нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогтоо тохируулан тооцуулах

**Зөвлөмж:**

- Оюутны сайн дурын ажил буюу нийгэмд чиглэсэн сайн үйлсийг багц цагаар тооцож, үнэлэх талаар санаачилгатай ажиллах

### 5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

Сүүлийн 5 жилийн хугацаанд "Хөдөлмөр засалч" хөтөлбөрт суралцагчдын 12% нь оюутны хөгжлийн зээл, 2% нь төрийн сангийн буцалтгүй тусламж, 5% нь тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдсан байна. Суралцагч оюутан байх хугацаандаа олон нийтийн ажилд өндөр оролцоотой оролцдог тухай тайлан болон ярилцлагаас тодорхой харагдаж байна.

<u>Дараах нотолгоонуудаар нотлогдсон:</u>

- Сувилахуйн сургуулийн Оюутны зөвлөлийн дүрэм, журам
- Сувилахуйн сургуулийн оюутны клубүүдийн төлөвлөгөө, тайлан
- Гамшгаас хамгаалах сургалтад хамрагдсан тухай тайлан
- Дусал цус- Дүүрэн амьдрал аяны тайлан
- Coffee corner тайлан
- ДОХ-ын эсрэг өдөр - 2021 төлөвлөгөө, тайлан
- Хөдөлмөр засалч болон хөдөлгөөн засалч мэргэжлээр тэтгэлэгт сургалтад хамрагдах тухай
- Япон улсын Гунма их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулдаг эрт үеийн танилцах дадлага хийсэн оюутны тайлан

- Швейцар улсын Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургуульд ОУ-ын өвлийн сургалтанд оролцсон оюутны тайлан

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Монгол улсын засгийн газар, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлж буй "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн хүрээнд Хөдөлмөр засал болон хөдөлгөөн заслын мэргэжлээр суралцах хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх үйл ажилагааг 2022-2024 оны хичээлийн жилд зохион байгуулахаар төлөвлөж, тэтгэлэгт хөтөлбөрийг 5 ангилалын дагуу зарлаж, сургалтын тэтгэлэгт нийт 20 оюутанг элсүүлэхээр төлөвлөсөн нь онцлог, чухал ажил болсон байна.
- Япон улсын Гунма их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулдаг эрт үеийн танилцах дадлага хийдэг, Швейцар улсын Хэрэглээний Шинжлэх Ухааны Их Сургуульд ОУ-ын өвлийн сургалтанд жил бүр мэргэжлийн багш нар оролцож, хамтран ажиллаж, суралцаж, туршлага хуримтлуулдаг нь чухал үр дүнтэй, онцлог ажил байна.

**Анхаарах асуудал:**

- Сургуулийн зүгээс Хөдөлмөр заслын хөтөлбөрийн оюутанд зориулсан тэтгэлэг санаачлан зохион байгуулах
- Тэтгэлэг болон бусад тусламж, оюутан солилцоо, оюутны хөгжлийн зээлд хамрагдах байдал нь хөдөлөр засалч мэргэжлээр элсэн суралцаж буй оюутны тоо харьцангуй цөөн байгаатай холбоотойгоор бусад мэргэжлийн оюутантай харьцуулахад харьцангуй бага байна.

**Зөвлөмж:**

- Бусад байгууллагуудтай хамтын ажиллааны гэрээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар анхаарах

### 5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг холбогдох дүрэм журмын хүрээнд оюутанд чирэгдэл учруулахгүйгээр уян хатан зохион байгуулдаг тухай тайлан, журам, холбогдох тушаалын хавралтаас нотлогдож байна.

<u>Дараах нотолгоонуудаар нотлогдсон:</u>

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 01 сарын 28-ны өдрийн А/19 тоот тушаал/ Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 6-р бүлэг
- АШУҮИС-ийн захирлын тушаал/ Оюутны шилжилт хөдөлгөөний тухай, 2021, 2020, 2019, 2018, 2017

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сар бүрийн төгсгөлд оюутны шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг нэгтгэж, Боловсрол хариуцсан дэд захирлаар хянуулан, улирал тутамд АШУҮИС-ийн захирлын тушаалаар шийдвэрлэдэг болсон нь оюутанд чирэгдэл багатай болсон байна. Хуучин журамд бүрэлдэхүүн сургуулийн аргазүйч нар тухайн хичээлийн жилийн 3-р сарын 01-ээс 6-р сарын 01-ны дотор хүлээн авч, 7-р сарын 01-ны дотор шийдвэрлэдэг байсныг өөрчилснөөр зарим тохиолдолд хичээлийн улирал болон жил дамнаж сунжирсан байдал гарахаас сэргийлэх боломжийг бүрдүүлсэн байна.
- Түр чөлөөнөөс эргэн суралцах, шилжин ирж суралцах, жилийн чөлөө авах, суралцах эрхийг түдгэлзүүлэх, сургуулиас бүрэн чөлөөлөгдөх зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үйл явц тус бүрийг шийдвэрлэх арга замыг тодорхой зураглан харуулж, журамд тусгасан нь онцлог байна.

**Анхаарах асуудал:**

- Ирэх хичээлийн жилээс хэрэгжүүлэхээр төлөвлөж “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хийгдэх Хөдөлмөр засал болон хөдөлгөөн заслын мэргэжлээр суралцах хүний нөөцийн дэмжлэг үзүүлэх үйл ажилагааг 2022-2024 оны хичээлийн жилд зохион байгуулахаар төлөвлөсөн тэтгэлэгт хөтөлбөр шилжин суралцах оюутны шилжилт хөдөлгөөнийг хэрхэн шийдэх талаар журамдаа тусгах

**Зөвлөмж:**

- Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой журмыг оюутны веб-д оюутанд харагдах байдлаар оруулах

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

Төгсөлтийн мэргэжлийн салбар комиссын шийдвэрийг үндэслэн бакалавр болон дипломын зэргийн болзол хангасан төгсөгчдөд АШУҮИС-ийн захирлын тушаалаар мэргэжил, боловсролын зэрэг, диплом, энгэрийн тэмдэг олгодог нь дүрэм журамтай нийцэж байна. Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан бөгөөд англи, монгол хэл дээр хавсралт хэвлэгдэж байгаа нь гадаад улс оронд тухайн судалсан хичээлийг хүлээн зөвшөөрөх боломжтой болгож байна.

<u>Дараах нотолгоонуудаар нотлогдсон:</u>

- АШУҮИС-ийн захирлын 2021 оны 28-ны өдрийн А/19 тоот тушаал / Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Төгсөлтийн дипломын хуулбар /загвар/
- Төгсөгчдөд энгэрийн тэмдэг, дардас, диплом олгох тухай АШУҮИС-ийн захиралын тушаал – 2021, 2020, 2019, 2018

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөлтийн бичиг баримтад тусгагдах нэр, томъёо болон хичээлийн англи, монгол хэл дээрх нэр, нэршлийг АШУҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх нэр томъёоны зөвлөлөөр хэлэлцүүлж, батлагдсан нэр томъёог тусгадаг нь онцлог байв.
- 2020-2021 оны хичээлийн жилд төгсөгчдийн дипломын хавсралтын алдаагүй байдал, бүрдэл хэсгүүдийн чанар, орчуулгын шинэчлэлд хяналт үнэлгээ хийсэн нь чухал ажил болсон байна.

**Анхаарах асуудал:**

- Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд онлайнаар лавлагаа авах боломжийг бүрдүүлэх

**Зөвлөмж:**

- Хичээлийн жил бүрийн төгсгөлд төгсөгчдийн дипломын хавсралтын алдаагүй байдал, бүрдэл хэсгүүдийн чанар, орчуулгын шинэчлэлд хяналт үнэлгээ хийдэг байх хэрэгтэй.

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН**

## Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам батлах тухай АШУҮИС-ийн захиралын 2021 оны 5-р сарын 13-ны А/103 дугаар тушаалын 2-р хэсэгт заасан багш сонгон шалгаруулах журмаар зохицуулагдан багшлах хүний нөөцийг хангаж байна. Мэргэжлийн тэнхим их сургуулийн бодлого чиглэл, их сургуулийн сургалтын асуудал хариуцсан нэгжээс гаргасан тэнхимийн сургалтын ачаалал, багш нарын орон тоонд үндэслэн шинээр багш авах шаардлагатай эсэх үндэслэлийг гаргаж, төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлаж багшаар ажилд орохыг хүссэн эмч, судлаач, мэргэжилтэн, үндсэн багшид тавих шалгуурлыг хангасан хэн бүрт сонгон шалгаруулалт нээлттэй зарлаж өмнө нь багшилсан туршлага, мэргэжлийн салбартаа гаргасан амжилт, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг биелүүлсэн байдал зэргийг харгалзан “Багш” хүртэлх албан тушаалд шууд дэвшүүлэн ажиллуулдаг.

<u>Мэргэжлийн багшийн хүний нөөц:</u>

ЭМШУИС болон Швейцар улсын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их сургууль (ЦХШИС) хоорондын харилцан зөвшилцлийн санамж бичигт 2008 оны 3-р сарын 12нд гэрээ байгуулагдаж, сэргээн засах анагаах ухааны салбарт хөдөлмөр засалч мэргэжилтэнг бэлтгэх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн.
2013 оны 9-р сард Гүнма Японы Гунма их сургуулийн Анагаах ухааны салбар сургууль болон Монголбн ЭМШУИС хоорондын хамтын ажиллагааны хүрээнд сургалтын хөтөлбөр

боловсруулсан. БШУЯ-ны шаардлагын дагуу сургалтын төлөвлөгөө нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэжлийн гэсэн бүтэцтэй. Ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлүүдийн багшлах боловсон хүчин АШУҮИС-ийн хүрээнд хангалттай. Мэргэжлийн хичээлийн багшлах боловсон хүчин зайлшгүй хэрэгтэй болсон. ЦХШИС-ийн Эрүүл мэндийн мэргэжилтний сургууль болон Японы Гунма их сургуультай хамтын ажиллагааны хүрээнд багшлах бүрэлдэхүүнээ сургалтанд хамруулах  заах арга, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн ажилласан.

2015-2021 оны хугацаанд дараах багш нар мэргэжлээ дээшлүүлсэн. Үүнд:

| **Он** | **Хаана, ямар сургалтанд хамрагдсан** | **Багшийн нэр** |
|---|---|---|
| 2015-2017 | Хөдөлмөр заслын шинжлэх ухааны Европын магистр | М.Эрдэнэцэцэг |
| 2016-2017 | Япон улсын Гүнма их сургуульд магистр | С.Булганчимэг |
| Хөдөлмөр заслын мэргэжжилтнүүдийн жил бүр зохиогддог мэргэжлийн судлагдахууны багц | | |
| 2017 | Швейцарын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их суруупь (ЦХШИС)-ийн зохион байгуулдаг олон улсын өвлийн сургалт | М.Эрдэнэцэцэг |
| 2018 | Швейцарын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их суруупь (ЦХШИС)-ийн зохион байгуулдаг олон улсын өвлийн сургалт | М.Эрдэнэцэцэг |
| 2019 | “Хөдөлмөр заслын Европын холбооны боловсролын хурал” сургалт (ENOTHE)<br>Швейцарын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их суруупь (ЦХШИС)-ийн зохион байгуулдаг олон улсын өвлийн сургалт<br>Японы хөдөлмөр заслын холбооны хурал -57 | М.Эрдэнэцэцэг<br>С.Булганчимэг |
| 2020 | Швейцарын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их суруупь (ЦХШИС)-ийн зохион байгуулдаг олон улсын өвлийн сургалт | М.Эрдэнэцэцэг<br>С.Булганчимэг |
| 2021 | Швейцарын Цүрихийн хэрэглээний шинжлэх ухааны их суруупь (ЦХШИС)-ийн зохион байгуулдаг олон улсын өвлийн сургалт /цахим/ | М.Эрдэнэцэцэг<br>С.Булганчимэг<br>С.Долгорсүрэн |

Хөдөлмөр засалч бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын бүтэц бүрэлдэхүүн түүний залгамж халаа нь сургалтын үнэ цэнийг үзүүлэх гол үзүүлэлт билээ. Бие бялдар судлалын тэнхмийн багш бүрэлдэхүүн одоогоор 8 багшийн орон тоотойгоор сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Хүний нөөцийн хувьд мэргэжлийн ур чадвар, дадлага туршлага сайтан япон, монгол багшлах боловсон хүчинтэйгээр сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.

Хөдөлмөр засалч мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багшийн хүний нөөц

| **№** | **Нэрс** | **Мэргэжил** | **Цол зэрэг** | **Тэнхим** | **Багшилсан жил** | **Нэмэлт тайлбар** |
|---|---|---|---|---|---|---|
| **Ерөнхий суурь** | | | | | | |
| 1. | Ж.Мөнхханд | Сувилагч | АУ-ы доктор | ССТ | 4 жил | Декриттэй |
| 2. | И.Нарантуяа | Гадаад хэлний багш | Магистр | ЕЭТ | 3 хүртлэх жил | |
| 3. | Ч.Батчимэг | Биеийн тамрын арга зүйч | Магистр | ЕЭТ | 5-с дээш | |
| 4. | Г.Сүхбат | Биеийн тамрын арга зүйч | Магистр | ЕЭТ | 5-с дээш | |
| 5. | Г.Бат-эрдэнэ | Физик электроникч | Магистр | ЕЭТ | 3 хүртлэх жил | |
| 6. | П.Орхонтуяа | Химийн багш | АУ-ы доктор | ЕЭТ | 3 хүртлэх жил | |
| 7. | А.Гэрэлмаа | Хүний их эмч | Магистр | ЕЭТ | 5-с дээш | |
| 8. | Б.Буяндэлгэр | Философич-багш | ФУ-ны доктор | ЕЭТ | 5-с дээш | |
| 9. | Э.Батмандуул | Эрүүл мэндийн эдийн засагч | Магистр | НЭМС-ЭМБТ | 5-с дээш | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10. | Б.Чойням | Хүний их эмч | Магистр | АСШУТ | 5-с дээш | АШУҮИС-ын захиргааруу шилжсэн. |
| 11. | Ж.Отгонбат | Хүний их эмч | Магистр | АСШУТ | 3 хүртлэх жил | |
| 12. | Ч.Оюунаа | Гадад хэлний багш | Магистр | ЕЭТ | 5-с дээш | |
| 13. | Б.Одгэрэл | Эрүүл мэндийн мэдээлэл зүйч | Магистр | ЕЭТ | 5-с дээш | |
